

ЖИЛИЙН ТАЙЛАН 2018

Уур амьсгалын ногоон сангийн
**ҮНДЭСНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГА**



**GREEN
CLIMATE
FUND**

Эрхэм зорилго

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Хэтийн зорилт

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.

Бидний тухай

ХасБанк нь 2001 онд байгуулагдсан цагаасаа Монгол Улсын банк санхүүгийн системд тогтвортой өсөлтийг бий болгож, үйл ажиллагаагаа өргөтгөж ирсэн бөгөөд өдгөө системийн хэмжээний 4 том банкны нэг болоод байна. Компанийн засаглал, нийгмийн хариуцлагаараа салбартаа тэргүүлэгч ХасБанк нь Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй 76 салбар нэгж, 1,200 мэргэшсэн ажилтан, 5,000 гаруй мерчант, 350 гаруй АТМ-аар дамжуулан 1 сая харилцагчдадаа санхүүгийн цогц үйлчилгээг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан, нэр төртэйгээр хурдан шуурхай хүргэж байна.

Агуулга

2018 оны онцлох үйл явдал	4
Санхүүгийн гүйцэтгэл	6
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	8
Төлөөлөн Удирдах Зөвлөл	9
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	10

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	13
Гүйцэтгэх удирдлага	15
ИРГЭДИЙН БАНК	
Иргэдийн банкны үйл ажиллагаа	17
Салбарын удирдлага	18
Харилцагчдыг хамгаалах зарчмууд	19
БИЗНЕС БАНК	
Бизнес банкны үйл ажиллагаа	21
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд	22
Хүний нөөц	24
Компанийн нийгмийн хариуцлага	28

ЭХ ДЭЛХИЙ

Байгаль Орчны Хариуцлага	32
Эко Банкны үйл ажиллагаа	34

ЭРҮҮЛ АШИГ

Бизнесийн үйл ажиллагааны орчин	38
Банкны салбар	40
2018 оны санхүүгийн жил	42
Эрсдэлийн удирдлага	43
Мэдээллийн технологи	46
Дотоод аудит	47
Компанийн засаглал	48
Шагналууд	54
Корреспондент банкууд	55

2018 оны онцлох үйл явдал

1-р сар

ХасБанк харилцагчдадаа улам ойртож, И-март, Бөмбөгөр, ICC tower салбаруудаа шинээр нээлээ.

3-р сар

Хүүхэд залууст санхүүгийн мэдлэг боловсрол олгох Global Money Week хөдөлгөөний хүрээнд 11 сургуулийн ахлах ангийн 1100 гаруй сурагчид мөнгөний ухаалаг зарцуулалтыг хэвшил болгох, хуримтлал болон төлбөрийн картын ач холбогдлыг таниулан ойлгуулах зорилготой сургалт, лекцүүдийг зохион байгууллаа.

5-р сар

Интернэт банкны веб системийн мэдээлэл дамжуулалтын аюулгүй байдлын үнэлгээ В байсныг А болгон дээд түвшинд хүргэлээ. Үнэлгээг олон улсын Qualys SSL Labs-ийн үнэлгээний систем баталгаажуулсан бөгөөд банкны систем дотроо хамгийн өндөр үзүүлэлт болсон.

Хасын хүлэгүүд сагсан бөмбөгийн баг МСБХ-ны дээд лигийн алтан цомыг 6 дахь удаагаа өргөж, түүхэнд байгаагүй амжилт үзүүлээ.

7-р сар

Олон улсын үнэлгээний Fitch Ratings агентлаг ХасБанкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шатлал ахиулж, “В-” байсныг “В” тогтвортой болгож өсгөлөө.

9-р сар

Харилцагчийн бичиг баримтыг цахим хэлбэрээр бүрдүүлэх ХУР системийг бүх салбар, тооцооны төвдөө нэвтрүүлээ.

11-р сар

“Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяны хүрээнд Монголбанк, МБХолбоо болон арилжааны банкууд хамтран “Дижитал гарц” сэдэвт өдөрлөг, TEDx talk арга хэмжээг зохион байгууллаа.



2-р сар

Олон улсын үнэлгээний Мүүдиз (www.moody's.com) агентлагаас ХасБанкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг В3 (тогтвортой) болгон сайжрууллаа. Ингэснээр ХасБанк Монгол Улсын банкны системдээ хамгийн сайн зэрэглэлтэй банкуудын нэг болсон юм.



4-р сар

Уур амьсгалын ногоон сан, Эрчим хүчний зохицуулах хороо болон Байгаль орчин уур амьсгалын сантай хамтран “Ногоон санхүүжилтийн хоёрдугаар чуулган”-ыг “Эрчим хүчний хэмнэлт” сэдвийн хүрээнд “Бид дэмжинэ” уриатайгаар зохион байгууллаа.

Planet Rating агентлагаар хийлгэсэн үнэлгээний үр дүнд Харилцагчийг хамгаалах ухаалаг хөдөлгөөний зарчмуудыг хэрэгжүүлдэг банк болохоо дахин баталлаа.

6-р сар

“Хүүхэд бүр уран бүтээлч” гар зургийн уралдааныг 3 дахь жилдээ зохион байгууллаа. Миний мөрөөдөл сэдвээр явагдсан тус уралдаанд 3-14 насны хүүхдүүдийн 600 орчим бүтээл ирсэн.



8-р сар

ХасБанкнаас дэмжлэг үзүүлсэн Байт харвааны “Дайчин чанар - тэсвэрийн талбар 360” талбай ашиглалтад орлоо.

10-р сар

Candy төлбөрийн картын зах зээлд шинээр нэвтрүүлээ. Мобиком корпоративтай хамтран гаргасан тус картыг ХасБанкны ПОС машинд уншуулан худалдан авалт, төлбөр тооцоо хийх бүрдээ үнийн дүнгийнхээ 1%-ийг candy болгон буцаан авна.


12-р сар

Мерси Кор олон улсын байгууллагатай хамтран Ногоон бэлчээр төслийг Хэнтий аймгийн Баян-Овоо суманд хэрэгжүүлэхээр боллоо.

Санхүүгийн гүйцэтгэл


Зээлийн багц
+39.2%

тэрбум төг.




Харилцах, хадгаламж
+22.7%

тэрбум төг.




Зээлээр авсан
санхүүжилт
-21.6%

тэрбум төг.




Нийт хөрөнгө
+1.5%

тэрбум төг.




Цэвэр ашиг
+3%


тэрбум төг.




Өөрийн хөрөнгийн өгөөж (%)
-1.2 нэгж



Хөрвөх чадвар (%)
-14.4 нэгж



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)
-1.1 нэгж



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /ТСН/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм.

ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ийм олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.

20.00%	МОНГОЛЫН АЛТ /МАК/	
17.17 %	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ	
16.81 %	ОРИКС КОРПОРАЦИ	
12.91 %	ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК	
10.52 %	КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК	
10.15 %	РОНОК ПАРТНЕРЗ	
6.63 %	МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ СЕРВИСИЗ	
3.73 %	ТРИОДОС ФЭЙР ШЭЙР ФАНД	
1.59 %	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ ТББ	
0.30 %	УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ ТББ	
0.10 %	МАГВАНЫ БОЛДОО	
0.09 %	ЧУЛУУНЫ ГАНБОЛД	

Төлөөлөн Удирдах Зөвлөл

(2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

ТУЗ-ИЙН ДАРГА

ЧулууныГанболд

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд дахин сонгогдсон.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Жулиан Хили

ТУЗ-ийн гишүүн
2018.03.29-нд дахин сонгогдсон.

Майкл Мадден

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд дахин сонгогдсон.

Санжай Гупта

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд сонгогдсон.

Риожи Нишимура

ТУЗ-ийн гишүүн
2018.03.29-нд сонгогдсон.

Нямтайширийн Цэлмүүн

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд дахин сонгогдсон.

Ив Жако

ТУЗ-ийн гишүүн
2018.03.29-нд дахин сонгогдсон.

Магваны Болдоо

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх Захирал
2017.03.30-нд дахин сонгогдсон.

Баянсаны Уламбаяр

Хараат бус гишүүн
2018.03.29-нд дахин сонгогдсон.

Нираж Вэдва

Хараат бус гишүүн
2018.06.13-нд томилогдсон.¹

¹2019.03.28-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдсон.

ТУЗ-ийн даргын мэндчилгээ



**Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид,
харилцагчид, түншүүд ээ,**

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн
өмнөөс ХасБанкны 2018 оны тайланг
танилцуулж байгаадаа баяртай байна.
Та бүхний байнгын дэмжлэг, хамтын
ажиллагаанд гүнээ талархаж байгаагаа
илэрхийлье.**

ЧулууныГанболд

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьд Банкны цэвэр ашиг 20.4 тэрбум байсан нь 4 дөх жилдээ эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран 20 тэрбумын босгыг давж ирсэн. Цэвэр ашиг төсвийн 65.7 хувийн гүйцэтгэлтэй байсан нь өнгөрсөн жил хөрөнгө оруулалтын өгөөж буурсан зэрэг шалтгаантай байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын зүгээс Стратеги 20/20-ийн дагуу хийгдэх хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн түвшинд хийхийн зэрэгцээ эх үүсвэрийн зардлыг бууруулах талаар дорвитой арга хэмжээ авч ажилласан.

Зээлийн багц 39 хувиар өсөж 2 их наяд төгрөгт хүрч, зах зээлд эзлэх хувь 10 хувиас 11 хувь хүртэл нэг жилийн дотор өсч, Банкны орлого 18 хувиар өсөж 339 тэрбум төгрөгт хүрсэний зэрэгцээ чанаргүй зээл 11 хувиар буурч, ХасБанк одоо Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны бүх үзүүлэлтийг хангасан, бусад банкуудтай харьцуулбал хамгийн бага буюу 5 хувийн чанаргүй зээлийн харьцаатай банк болоод байна.

2018 он нь Стратеги 20/20-ийг хэрэгжүүлэхэд чухал жил байв. Банк цахим сүлжээнд хийх хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлж, АТМ-ын тоог нэмэгдүүлж, мэдээллийн технологи болон бүтцийг сайжрууллаа. 2018 онд Банк иргэдийн зээлийн багцыг 41.6 хувиар нэмэгдүүлж, зах зээлд 12.3 хувь эзлэх болсон. Хадгаламж эзэмшигчдийн тоо өмнөх жилээс 10 хувиар нэмэгдэж, 776 мянган боллоо. Хадгаламж 23 хувиар өсөж 1,576 тэрбум төгрөгт хүрч, зах зээлд эзлэх хувь нь 10 хувь хүртэл нэмэгдлээ.

Банк жижиг, дунд бизнесүүдэд худалдааны санхүүжилт, зээлийн үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлж, худалдааны санхүүжилтээр Монголд 3 дахь том банк болоод байна. Өнгөрсөн жил ХасБанк EuroMoney зэрэг нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудаас шагнал авч, амжилтаа баталгаажууллаа.

ХасБанк ногоон санхүүжилтээр тэргүүлэх байр суурьтай байна. 2018 онд Говьсүмбэр аймагт 10 МВт-ын нарны цахилгаан станцийг барихад таатай нөхцөлөөр санхүүжилт олгож, ашиглалтад орууллаа. Банк Уур амьсгалын ногоон сантай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, харилцагчдад санхүүжилтийн үйлчилгээ үзүүлж байна.

Үйл ажиллагааг сайжруулах нь стратегийн зорилт бөгөөд төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашиглан харилцагчийн хурууны хээгээр лавлагаа авах, мэдээлэл шалгах системийг банкны үйл ажиллагаанд 2018 онд амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр харилцагчийн баримт бичгийг цахим байдлаар бүрдүүлэх боломжтой боллоо.

Банк хоёр жилийн өмнө эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчилж, “Хамгаалалтын Гурван Бүс”-ийн зарчимд үндэслэсэн эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлж, 2018 онд эрсдэлийг хэмжих, зээлийн шийдвэр гаргах, хянан нийцүүлэх ажиллагааг сайжруулах чиглэлээр ажиллалаа. Эрсдэлийг илрүүлэх, хэмжих, тодорхойлоход автоматжуулсан аргыг нэвтрүүллээ, Цахим болон мэдээллийн аюулгүй байдлыг цаашид сайжрууллаа. Эрсдэлийн удирдлага, тайлагналтын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

Цахимжуулалт, салбарын өөрчлөн байгуулалттай уялдуулан хүний нөөцийн бодлогод өөрчлөлт оруулж, бүтцийн өөрчлөлт хийхдээ ажиллагсдыг дотроо шилжүүлэх замаар нийгмийн хариуцлагатай байдлаар хэрэгжүүлэх, технологи хүн бүрийн өдөр тутмын амьдралд нэвтэрч салшгүй нэгэн хэсэг болохын хэрээр харилцагчид “цахим” сэтгэлгээтэй болж байгаа үед Банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалтын арга хэмжээнд анхаарч ажилласан. ХасБанк байгуулагдсанаа хойш зохистой сайн засаглалын зарчмыг байгууллагын соёл болгож, ТУЗ нь бие даасан саналтай, бизнесийн одоогийн болон ирээдүйн асуудлын шийдвэрлэх мэдлэг туршлагатай, гүйцэтгэх удирдлагын ажлыг хянаж, стратегийн

удирдлагаар хангах чадвартай байх нь бизнесийг хөгжүүлэх гол үндэс суурь хэмээн үзэж, 2018 онд ТУЗ энэ талаар чухал үүрэг гүйцэтгэв.

2018 онд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оров. ХасБанкны хараат гишүүнээр 4 жил ажилласан Жеймс Стент үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, оронд нь мэдээллийн технологи, банкны өөрчлөн байгуулалтын чиглэлээр 30 гаруй жил ажилласан туршлагатай Нираж Вэдва томилогдсон бөгөөд Нираж Вэдва стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

2018 онд мөн ОРИКС болон ЕСБХБ-наас нэр дэвшсэн Ёшиаки Мацүока ба Жулиан Хили нар эдгээр байгууллагын шийдвэрээр өөр ажил үүрэгтэй болсонтой холбогдуулан ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, оронд нь шинэ гишүүн Риожи Нишимура, Андрэж Витак нар ТУЗ-ийн гишүүнээр томилогдож байгаа. 2018 онд мөн хараат бус гишүүн Матью Уэлч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.

Эцэст нь миний бие ТУЗ-ийн даргаар 15 жил ажилласны дараа 2019 оны ХЭ-ийн ээлжит хурлаар ТУЗ-ийн даргын үүрэгт ажлаа хүлээлгэн өгч байгаагаа сэтгэл хангалуун мэдэгдэж байна. ХасБанкны ТУЗ-ийн даргаар ажилласан энэ хугацаанд хамтран ажиллаж байсан олон нэр хүндтэй дотоодын болон олон улсын Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, чадварлаг гүйцэтгэх удирдлагын гишүүд, ажиллагсдад чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна. Мөн хорин жилийн өмнө ХасБанкны үндэс суурийг хамт тавилцаж байсан Магваны Болдоо болон түүний удирдлагын багт талархаж байгаагаа илэрхийлж, ХасБанкны ТУЗ-ийн даргаар ажиллах нь асар том нэр хүнд, хариуцлага байсныг хэлмээр байна.

ХасБанк, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК 2019 оныг шинэчилсэн стратегитай угтаж, стратегийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж байгаад баяртай байна. Хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүддээ ажлын өндөр амжилт хүсье.

Эрдэнэт хүмүүн



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

**Эрхэм Тэнгэрчүүд, Хасчуудаа,
Эрхэм ТУЗ-ийн гишүүд, Хувьцаа
эзэмшигчид, зохицуулагч байгууллагууд,
харилцагч түншүүд, хамтран ажиллагсад аа,**



Магваны Болдоо
Гүйцэтгэх захирал

2018 онд ХасБанк Стратеги 20/20-ийн хэрэгжилтийн үргэлжлүүлж, олон улсын стандартыг тууштай мөрддөг, эрүүл, тогтвортой статустай, зээлийн багцын удирдлагын зохистой тогтолцоотой, зохистой засаглалтай, хариуцлагатай банк гэдэг нэр хүндээ улам бататгалаа. Стратеги 20/20-ийн дагуу хийгдэх хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн түвшинд хийхийн зэрэгцээ эх үүсвэрийн зардлыг бууруулах талаар дорвитой арга хэмжээ авч ажиллалаа. Өнөөдөр технологи хүн бүрийн өдөр тутмын амьдралд нэвтэрч салшгүй нэгэн хэсэг болохын хэрээр харилцагчид “цахим” сэтгэлгээтэй болж байгаа үед цахимжуулалт, салбарын өөрчлөн байгуулалтыг амжилттай хийж хэрэгжүүлж байна.

Банк өсөлт хөгжлийнхөө дараагийн шатанд шилжин орж байгаа энэ үед би залгамж халаа бэлтгэх төлөвлөгөөний дагуу үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, шинэ үеийн манлайлагчид банкны удирдлагыг шилжүүлэх шийдвэрийг гаргасан. 2019 оны 3 дугаар сард ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн Дарга болон Гүйцэтгэх захирлын түвшинд удирдлага нэгэн зэрэг шилжиж, ТСН ХХК, ХасБанк шинэ удирдлагатай боллоо.

Энэ завшааныг ашиглаад Та бүгдэд цөөн хэдэн зүйл хэлье. Юуны өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБ-ын ХХ)-өөс эхлүүлсэн МикроСтарт төсөл ХасБанкны эхлэлийг тавихаас өмнө анхнаас нь олон жил хамтарч ажилласан ХасБанк ба ТСН-ийн ТУЗ-ын дарга Ч. Ганболд даргад талархал илэрхийлж цаашдын ажил амьдралд нь амжилт хүсье. ХасБанк ба ТСН-ийн ТУЗ-ийн даргаар шинээр томилогдсон Санжэй Гупта танд баяр хүргэж, энэхүү чухал албанд бидэнтэй хамтран ажиллахыг зөвшөөрсөнд талархаж байна. Банкны шинэ Гүйцэтгэх захирлаар томилогдох Гүмэнжавын Цэвэгжавт баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсч байна. Банк шинэ удирдлагад шилжих шилжилтийн явцад зөвлөх үйлчилгээний гэрээгээр дэмжлэг үзүүлж ажиллана.

Гүйцэтгэх удирдлага

(2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

Магваны Болдоо

Гүйцэтгэх захирал
2014.07.10-нд томилогдсон

Ганибалын Амартүвшин

Ерөнхий захирал, Бизнесийн банк
2014.07.10-нд томилогдсон

Гүмэнжавын Цэвэгжав

Ерөнхий захирал, Иргэдийн банк
2018.11.21-нд томилогдсон

Ганзоригийн Эрдэнэбаяр

Санхүү хариуцсан захирал
2013.01.07 -нд томилогдсон

Торстен Клайн Бойнинг

Эрсдэл хариуцсан захирал
2017.01.01-нд томилогдсон

Ганзоригийн Зул

Хүний нөөц хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Арвинд Жоши

Мэдээллийн технологи хариуцсан захирал
2017.04.19 -нд томилогдсон

Энэбишийн Уламбаяр

Үйл ажиллагаа хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Энхбаярын Ундармаа

Ерөнхий аудитор
2016.05.05-нд томилогдсон

Дашнямын Ашидмаа

Засаглал хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Сандагдоржийн Болд

Ерөнхий эдийн засагч
2016.09.12-нд томилогдсон

Юндэнгийн Гэрэлмаа

Зээл хариуцсан захирал
2006.01.18-нд томилогдсон

ТУЗ-ийн хүндэт дарга Ч.Ганболд манай компанийг Монгол Улсад төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн шилдэг засаглалтай байгууллага болоход ихээхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ТУЗ-ийн шинээр томилогдсон Санжэй Гупта дарга энэ буухиаг үргэлжлүүлэн улам бэхжүүлнэ гэдэгт итгэж байна.

ХасБанкны Гүйцэтгэх захирлаар ажиллах хугацаанд итгэл, дэмжлэг үзүүлж хамтран ажилласан бүх хүмүүст талархаж байгаагаа илэрхийлж байна. Анх 1997 онд Монгол Услын Засгийн газар, НҮБ-ын санаачилгаар бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэх ажлыг эхлүүлэх уулзалт хэлэлцүүлгүүдэд оролцож, Монголия МикроСтарт Төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулагдснаас хойш нэг сая долларын энэ төсөл нэг тэрбум доллар гаруй активтай, системийн нөлөө бүхий банк болж, бичил харилцагчид бодит эдийн засгийн үндэс суурийг бүрдүүлдэг амжилттай өсч буй жижиг дунд үйлдвэрүүд болон хөгжсөн билээ.

Бид асар том амжилтад хүрсэн. Энэ амжилтад үндсэн 3 хүчин зүйл нөлөөлсөн. Нэгдүгээрт, Олон улсын хүчтэй дэмжлэг. Хоёрдугаарт, Монгол Улсын банк санхүүгийн эрх зүйн таатай орчин. Гуравдугаарт, Та бүгд буюу ур чадвартай удирдлагын баг, хамт олон юм. Энэ гурван хүчин зүйлийн ач холбогдлыг бид сайтар тунгаан бодож хайрлаж хамгаалж явах ёстой. Олон улсын хүчтэй дэмжлэгээ алдаж болохгүй. Өнөөдөр банк санхүүгийн эрх зүйн орчин ойр ойр өөрчлөгдөж түвэгтэй байгааг бид харж байна. Хүлцэнгүй хараад суух биш банк санхүүгийн эрх зүйн таатай орчноо дор бүрнээ хамгаалж тэмцэх хэрэгтэй. Удирдлагын баг, хамт олон хүрсэн амжилтдаа Санжэй даргын хэлснээр санаа амарлингуй байх бус өөрсдийгөө тасралтгүй цэнэглэж хөгжүүлэх хэрэгтэй байна.

Бид олон улсын хүчтэй дэмжлэгт түшиглэн босож ирсэн тухай дээр дурдсан. Одоо ч энэ дэмжлэг хэвээр байна. ТСН-ийн нийт хувьцааны 80 хувийг олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагууд, хувийн банк санхүүгийн байгууллага эзэмшиж байгаа бөгөөд зарим нь Токио, Нью-Йорк, Торонтогийн хөрөнгийн бирж дээр гарсан нэр хүндтэй хөрөнгө оруулагчид байна. Бид сайн явбал манай хувьцаа эзэмшигчид сайн явах, манай хувьцаа эзэмшигчид сайн явбал бид сайн байх ийм нарийн хэлхээ холбоотой олон улсын компани гэдгээ бид мартах ёсгүй.

ТСН, ХасБанканд Та бүгдтэй хамтран ажиллахад надад хамгийн их урам зориг, эрч хүч өгдөг зүйл бол манай компанийн соёл, бидний эрхэм зорилго, алсын харааг тодорхойлдог Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашиг хэмээх гурван тулгуурт зарчим юм. Энэ гурван тулгуур зарчмыг мах цусандаа шингэтэл, сэтгэл зүрхээрээ ойлгож мэдэрснээр бидний шинийг эрэлхийлэх бүтээлч санал санаачилга тасрахгүй. Энэ уламжлалаа хадгалж явна гэж Та бүхэнд найдаж байна.

Мэдээж хэрэг бэрхшээлтэй асуудал зөндөө байгаа. Харин удирдах ажилтан бид бэрхшээлтэй байна гэж гомдоллох биш тэдгээрийг шийдэхийн тулд энд хамт байгаа. Бидэнд итгэж мөнгөө хадгалуулсан бидэнтэй харилцдаг олон мянган харилцагчдын итгэлийг алдахгүйн тулд, харилцагчдынхаа бэрхшээл хүндрэлийг бага боловч нимгэлэхийн тулд бид санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна.

Шинээр сонгогдсон Г.Цэвэгжав Гүйцэтгэх захиралд амжилт хүсэхийн ялдамд ТСН ба ХасБанкны шинэ үеийг манлайлан амжилттай ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хамтдаа бэрхшээл зовлон хямралыг даван туулж ард нь гарч байсан, амжилтад хүрээд баярлаж хөөрч хамтран ажилласан авьяаслаг эрч хүчтэй цоглог багийн хамт олондоо баярлалаа. Та бүгдтэй хамтран ажиллах аз завшаан надад тохиолдсон нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа.

Өнгөрсөн хугацаанд ХасБанкыг банк санхүүгийн салбарт тэргүүлэх байгууллагуудын нэг болгоход хувь нэмэр оруулж, хамтын хичээл зүтгэл гаргаж дэмжиж ирсэн бүх Хувьцаа эзэмшигч, ТУЗ, удирдлагын баг, бүх ажиллагсдад талархал илэрхийлж, цаашдын ажилд амжилт хүсч, цаашдын ажил амьдралд тань өндөр амжилт, эрүүл мэнд, аз жаргалтай байхыг хүсье.

Иргэдийн Банк



ЗЭЭЛИЙН БАГЦ

2018 онд иргэдийн зээлийн багцыг 39.5 хувиар нэмэгдүүлснээр, зах зээлд эзлэх хувь хэмжээ 12.3 хувьд хүрлээ. Тэр дундаа иргэдийн хэрэглээний зээлийн багц 62.1 хувь, бизнесийн зээлийн багц 37.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөллөө.

ХасБанк нь харилцагч нарынхаа үнэт цагийг хэмнэх, санхүүгийн хэрэгцээ шаардлагыг түргэн шуурхай шийдэх зорилгоор технологийн дэвшил, инновацийн хялбар шийдэлийг дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажилласан нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын 9 болон 12 дугаар зорилгуудтай нийцэж байна. Үүний үр дүнд харилцагч гар утаснаасаа хадгаламж барьцаалсан зээлийг 8 секундын дотор авах, НӨАТ-н буцаан авалтыг урьдчилан авах зэрэг боломжтой боллоо. Түүнчлэн, Үндэсний дата төвтэй хамтран төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүллээ.



Түүнчлэн Хобби сургууль болон Орчлон сургууль цэцэрлэгийн цогцолбор БСБ нартай хамтран хөнгөлөлттэй нөхцөлтэй сургалтын төлбөрийн зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн.

ХАДГАЛАМЖИЙН БАГЦ:

Өмнөх оноос хадгаламж эзэмшигчийн тоо 10 хувиар нэмэгдэж 2018 оны эцэст 776 гаруй мянган хадгаламж эзэмшигчтэй боллоо. Мянга мянган харилцагч, хадгаламж эзэмшигчдийн маань бидэнд хүлээлгэсэн итгэл найдварын дүнд нийт хадгаламжийн хэмжээ 23 хувиар өсөж 1,576 тэрбум төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх хувиа 0.6 хувиар нэмэгдүүлж, 10.1 хувьд хүргэлээ. Хадгаламжийн багцын 41 хувийг хугацаагүй эх үүсвэр эзэлж байгаа нь хадгаламжийн эх үүсвэрийн зардлыг тогтвортой хадгалах гол хүчин зүйл болсон.



Харилцагчдад технологийн шинэчлэлээр дамжуулж улам их боломжийг олгох нь

Технологийн дэвшлийг аливаа бизнесийн байгууллага өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр илүү үр ашигтай ажиллаад зогсохгүй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд гаргах боломж бүрдэж, эцэст нь харилцагчид ямагт хожиж байдаг. ХасБанк харилцагчиддаа шинэ бүтээгдэхүүн, түргэн шуурхай үйлчилгээг тогтмол хүргэх, банкны салбарт технологийн манлайлагч байх зорилгын хүрээнд цахим шилжилтийг эхлүүлэх бэлтгэл ажлыг 2018 онд амжилттай хийж гүйцэтгэсэн.

ХасБанк нь шинэ боломж, үйлчилгээг цаг алдалгүй нэвтрүүлж харилцагчдадаа хүргэхийн тулд төлбөр тооцоо, лоялти чиглэлээр үйлчилгээ явуулж буй гарааны бизнес, финтек компаниудтай нягт хамтран ажиллах стратегийг хэрэгжүүлж эхлээд байна.

Тус стратегийн хүрээнд бид Candy, RedPoint хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагаа эхэлсэн төдийгүй E-Mart сүлжээ дэлгүүртэй хамтран олон улсын стандарт бүхий бэлгийн картыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.



ХасБанкны хувьд харилцагчдынхаа хэрэгцээнд тулгуурлаж тухайн хувь хүнд тохирох бүтээгдэхүүнийг бий болгож, банк, төлбөр тооцооны үйлчилгээг өдөр тутамдаа ямар ч асуудалгүй ашиглах боломжийг бүрдүүлэх нь туйлын зорилго юм.

Бид 2017 оны амжилт дээрээ тулгуурлан цахим сувгуудад оруулж буй хөрөнгө оруулалтаа улам эрчимжүүлж АТМ-ынхээ сүлжээг 62%-иар, ПОС төхөөрөмжийн сүлжээгээ 56%-иар тус тус нэмэгдүүлсэн. ХасБанкны харилцагчид Монгол улсын хэмжээнд 24/7 цагаар ажилладаг орлого бөгөөд зарлагын АТМ-үүд бүхий Экспресс банкаар үйлчлүүлж эхлээд байна.

2018 оны 4 сард ХасБанк урамшуулал, RedPoint хөтөлбөртэй хамтын ажиллагааны гэрээ зурж хамтарч ажиллах болсноор ХасБанкны харилцагчид картын хэрэглээ тутамдаа RedPoint оноо цуглуулж улмаар RedPoint каталоогоос төрөл бүрийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс 51%-ийн хямдралтай худалдан авах боломжтой болсон.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн том сүлжээ дэлгүүрүүдийн нэг болох E-Mart-тай хамтран бэлгийн карт буюу gift card-г нэвтрүүлсэн. Энэ нь борлуулалт, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад баталгаатай, аюулгүй, урьдчилсан төлбөрт картын шийдлийг санал болгож бэлэн бус төлбөр тооцоог хялбарчилж буй нэгэн хэлбэр юм.

ХасБанк нь 2018 онд зайнаас уншдаг контактлесс NFC технологийг албан ёсоор амжилттай нэвтрүүлж чадсан. Ингэснээр цаашид ХасБанкны гаргах бүх дебит болон кредит картууд болон ПОС төхөөрөмжүүд зайнаас уншдаг болж олон улсын бэлэн бус төлбөр тооцооны трендтэй хөл нийлүүлэн алхахаар болж байна. ХасБанкны харилцагч гадаадад аялж байхдаа картаа зайнаас уншуулж бага дүнтэй худалдан авалтыг заавал пин код хийхгүйгээр хялбархан, түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой болсон.

ХасБанк нь ирэх жилүүдэд цахим шилжилтийг улам эрчимжүүлж Монгол улсын банкны салбарт шинэ технологийг тогтмол нутагшуулж, технологийн манлайлагч байх том зорилготойгоор урагшлах бөгөөд энэ явцдаа харилцагчдадаа үргэлж тэргүүн байранд тавьж, харилцагчдынхаа хэрэгцээнд суурилсан, өдөр тутмын банкны үйлчилгээг улам хялбарчилсан шинэлэг шийдлүүдийг зах зээлд нэвтрүүлэн ажиллах болно.

Иргэдийн Банк

Салбарын удирдлага

Иргэдийн банкны стратегийн зорилт нь биет салбарын үйлчилгээнээс цахим сувгийн үйлчилгээ рүү шат дараатай шилжих, цахим бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, боловсронгуй болгоход чиглэж байна. Хэдий тийм боловч харилцагчид банкны үйлчилгээ авахын тулд биет салбараар үйлчлүүлэх, банкны ажилтнуудаас санхүүгийн зөвлөгөөг биечлэн авах сонирхол хэвээр байна.

Үүнтэй уялдуулан харилцагчид тав тухтай үйлчилгээ үзүүлэх зорилгоор салбаруудад хөрөнгө оруулалт хийхээс гадна харилцагчид санхүүгийн зөвлөгөө өгдөг ажилтнуудыг шинээр авах, сургах ажлыг зохион байгууллаа.

Салбар нэгжийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон харилцагчид ойр үйлчилгээ үзүүлэх зорилгоор зарим чухал байршилд шинээр салбар, нэгж нээлээ. 2017 онд салбар, нэгжийн тоо 82 байсан бол 2018 оны эцсийн байдлаар 88 болж өссөн.

Улаанбаатар хот	
Салбар	11
Тооцооны төв	27
Өргөтгөл	4
Хөдөө орон нутаг	
Салбар	23
Тооцооны төв	17
Өргөтгөл	6
НИЙТ	88



Харилцагчаа хамгаалах зарчмууд

Бид дэлхий дахинд дэмжигдсэн Харилцагчаа хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Францад төвтэй, бичил санхүү, нийгмийн хариуцлагын рейтинг тогтоодог, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Planet Rating агентлаг 2015 онд ХасБанканд үнэлгээ хийж, 2017 онд манай ТУЗ Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг баримталж ажиллахаа албан ёсоор дахин нотолж, Харилцагчдыг хамгаалах зарчмуудын бодлогоо шинэчлэн гаргасан юм.

1

Бүтээгдэхүүний зохих ёсны дизайн, хүргэлт

Бид бүтээгдэхүүн, түүнийг хүргэх сувгийн дизайныг харилцагчдад хохирол учруулахгүйгээр гаргахад зохих анхаарал тавина. Бүтээгдэхүүн, хүргэлтийн сувгийн дизайн гаргахдаа харилцагчдын онцлогийг тусгана.

Хэт их өр зээлтэй болохоос сэргийлнэ

Бид зээл олгох ажлын бүхий л үе шатанд харилцагч хэт их өрөнд оролгүйгээр зээлээ төлөх чадвартай эсэхийг тодруулахад зохих анхаарал тавьж ажиллана. Бид хэт их өр зээлтэй болохоос сэргийлэх дотоод систем нэвтрүүлэн, мониторинг хийж, зах зээлийн түвшний зээлийн эрсдэлийн удирдлагаа сайжруулах хүчин чармайлтыг дэмжиж ажиллана.

2

3

Ил тод байдал

Бид тодорхой, хангалттай, цаг үеийн мэдээллийг мэдлэгтэй шийдвэр гаргах хэмжээнд ойлгож чадах хэлбэр, хэлээр харилцагчдад хүргэхийг чармайж ажиллана. Бүтээгдэхүүний үнэ өртөг, нэр томъёо, нөхцөл болзлын тухай ил тод мэдээллийн хэрэгцээнд илүү анхаарал тавина.

Үнийг хариуцлагатай тогтооно

Үнэ тогтоох, нэр томъёо, нөхцөл гаргахдаа Банкны тогтвортой ажиллагааг хангахын зэрэгцээ харилцагчдад боломжийн хэмжээнд байлгахад анхаарна. Байгууллагын удирдлага хадгаламжийн бодит өгөөжийг ашигтай байлгахын төлөө ажиллана.

4

5

Үйлчлүүлэгчдэд шударга, хүндэтгэлтэй хандана

Бид харилцагчидтайгаа шударга, хүндэтгэлтэй харьцахыг чармайн ажиллах болно. Бид ялгаварлан гадуурхахгүй. Байгууллагын удирдлага авилгалын үйлдэл, мөн ажилтнууд болон агентуудын түрэмгий, зүй бус харьцаа, ялангуяа зээл борлуулах, өр барагдуулах ажиллагааны үеэрх тийм байдлыг илрүүлэх, засаж залруулах зохих ёсны арга хэмжээ авч ажиллана.

Харилцагчийн мэдээллийн нууцлалт

Хувь харилцагчийн дата мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн хүрээнд хүндэтгэн ажиллана. Дата мэдээллийг зөвхөн холбогдох мэдээлэл бүртгэж авах явцад, эсвэл хуульд өөрөөр заагаагүй бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглана.

6

7

Санал гомдол барагдуулах механизм

Байгууллагын удирдлага харилцагчдын санал гомдлыг хүлээн авч, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх хариуцлагатай механизм ажиллуулж, асуудал тус бүрийг шийдвэрлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулахад ашиглана.

Бизнес Банк

Бизнесийн Банк нь эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Бид 2018 онд зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласны үр дүнд зээлийн багц 39 хувиар, эх үүсвэрийн багц 11.5 хувиар, худалдааны санхүүжилтийн орлого 24.3 хувиар тус тус өслөө. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхдээ харилцагчийн бизнес, түүний онцлогийг харгалзан үзэж зээл, харилцах, хадгаламжийн данс, гадаад худалдааны санхүүжилт, валют арилжаа, төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн удирдлага болон бусад нэмэлт санхүүгийн үйлчилгээнүүдийг цогцоор нь хүргэн ажиллаж байна. Түүнчлэн бид байгууллага төдийгүй түүний хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлага, ажиллагсад мөн адил банкны үйлчилгээг цогцоор нь хүргэхийг зорьдог. 2018 онд авч хэрэгжүүлсэн онцлог ажлуудыг дурдвал:



- Харилцагч байгууллагуудын зээлийн хяналт хийхийн зэрэгцээ ирээдүйн хэрэгцээг тодорхойлж, урьдчилсан зээлийн эрх баталж ажиллалаа. Үүний үр дүнд зээл шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай, хүртээмжтэй болж чадсан.
- Европын Сэргээн Босголтын Банк (EBRD)-тай хамтран олгодог хамтын санхүүжилтийн зээлийг эрчимжүүлж, 44.0 тэрбум төгрөгийн олголт хийсэн бол 32.0 тэрбум төгрөгийн шийдвэр гараад, олголт хийгдэхээр хүлээгдэж байна. Тус зээл нь урт хугацаатай, хүү багатай байх тул харилцагчдын хэрэгцээнд маш сайн нийцдэг.
- Гадаадын банкуудад нээгдсэн худалдааны санхүүжилтийн шугамуудыг ашиглан гадаад худалдаа эрхлэгчдэд 30.0 гаруй сая ам.долларын богино хугацаатай, хямд хүүтэй эргэлтийн хөрөнгийн зээлүүдийг олгосон байна.
- Худалдааны санхүүжилтийн чиглэлээр 100 гаруй байгууллагад тусгайлсан сургалт, зөвлөгөө өгч ажилласан байна. Түүнчлэн МҮХАҮТ-тай хамтран худалдааны санхүүжилтийн хэрэглээ, ач холбогдлын талаар танхимын сургалт зохион байгуулж, 120 орчим жижиг, дунд бизнес эрхлэгчид хамрагдав.

Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд



ОУСК бол Дэлхийн банкны группын гишүүн, хөгжингүй зах зээлийн хувийн хэвшлийг дэмжих зорилттой дэлхийн хамгийн том санхүүгийн байгууллага юм. ОУСК нь ХасБанкны хувьцаа эзэмшигч бөгөөд ОУСК-ийн Капитализэцэн Сангаас хоёрдогч өглөгөө, ВИДФ сангаас бизнес эрхлэгч эмэгтэйнүүдийг дэмжих эх үүсвэр зэрэг олон төрлийн урт хугацааны санхүүжилт авдаг.



Европын сэргээн босголт, хөгжлийн банк ("ЕСБХБ") нь 1991 онд байгуулагдсан олон улсын хөрөнгө оруулалт хөгжлийн банк юм. ЕСБХБ нь үндсэн чиг үүрэгтээ байгаль орчны хариуцлага хүлээсэн анхны олон улсын банк бөгөөд 2017 онд 40 хувийн санхүүжилтээ ногоон хөрөнгө оруулалтад зориулах хэтийн зорилтдоо хүрсэн. ХасБанк болон ЕСБХБ-ны хоорондын урт хугацааны харилцаат хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалт, эх үүсвэр болон худалдааны санхүүжилт зэрэг багтана.



ODDO BHF нь Франц-Германы бие даасан санхүүгийн групп юм. Групп нь үйл ажиллагаагаа явуулж буй нутаг дэвсгэрийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмждэг. ODDO BHF Asset Management нь НҮБ-ын РПИ (Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим) -ийг хүндэтгэдэг 6.6 тэрбум еврогийн хөрөнгөөр байгаль орчин, нийгэм, засаглалыг дэмждэг хэд хэдэн сангийн хөрөнгийг удирддаг. 2018 онд ODDO BHF нь ХасБанкинд эх үүсвэр олгожээ.



SwedFund бол 1979 онд байгуулагдсан, Шведийн засгийн газрын эзэмшлийн хөгжлийн санхүүгийн байгууллага юм. Swedfund-ийн эрхэм зорилго нь хөгжиж буй орнуудын ирээдүйн нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад гол хувь нэмэр оруулж буй ажлын байр бий болгодог хувийн хэвшлийн салбар бизнесийг тогтвортой санхүүжүүлэх, хөгжүүлэх явдал юм. ХасБанк өөрийн бичил болон жижиг зээлдэгчдийг дэмжих зорилгоор SwedFund -с 2021 онд дуусах эх үүсвэрийг авсан байна.



Финляндын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны сан ("FinnFund") нь Финландын төрийн болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилттэй хөгжлийн санхүүгийн компани юм. Finnfund нь эрдэлийн хөрөнгө, урт хугацааны зээл, хөгжиж буй орнуудын хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийг олгож, улмаар тогтвортой хөгжлийг хангах төсөлийн хөрөнгө оруулалтынхаа бүх ашгийг ахин санхүүжилтээр эргэж олгох бодлого баримталдаг. 2016 онд Finnfund нь ХасБанкинд эх үүсвэр олгосон.



Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпораци ("OPIC") нь АНУ-ын засгийн газрын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. OPIC нь төслүүдээ санхүүжүүлсэн улс орнуудад салбарын болон бус нутгийн стандартыг дээшлүүлэх зорилготой. OPIC нь дэлхийн 160 гаруй оронд үйл ажиллагаагаа өргөжүүлж, өргөжиж буй бизнесийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийдэг. ХасБанк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2017 онд OPIC-с санхүүжилт авсан.



Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани ("ФМО")-ний дийлэнх хувийг Голландын засгийн газар эзэмшдэг ба гурван А үнэлгээтэй, хөгжлийн банк юм. ФМО нь гарааны бизнесийн хөгжлийг эдийн засгийн тогтвортой өсөлтийн түлхүүр гэж үздэг бөгөөд улмаар ард түмний амьжиргааны түвшин сайжрах боломжтой гэж үздэг. ФМО-ийн үндсэн чиг үүрэг бол урт хугацааны үр өгөөжтэй салбар, төслүүдэд, чиглэсэн хөрөнгө оруулалт хийх явдал юм. ХасБанк нь 2007 оноос хойш ФМО-тэй эх үүсвэр болон худалдааны санхүүжилтийн чиглэлээр хамтран ажилласаар байна.



Symbiotics бол хөгжиж буй орнуудын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл аж ахуй (БЖДҮ) болон дундаж болон түүнээс доош орлоготой өрхийг дэмжих, санхүүжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч хөрөнгө оруулалтын компани юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хувийн хэвшлийн эх үүсвэрийн удирдлага, зөвлөх үйлчилгээ зэргийг санал болгодог юм. Одоогийн байдлаар олон тооны зээлдэгчдийг хамарсан 20 гаруй санг удирддаг.



Triodos Investment Management BV ("Triodos") нь Триодос Банкны эзэмшлийн охин компани ба уг банк нь нийгэм, экологийн үр өгөөжид чиглэсэн бизнесийн тогтвортой хөгжлийг сурталчлах зарчим бүхий банкны анхдагчдын нэг юм. Тус байгууллагын хөрөнгө оруулалт нь эрчим хүч, санхүүгийн оролцоо, тогтвортой хөдөө аж ахуй, хувь эзэмших болон бонд зэрэг өргөн хүрээний стратегиудыг хамардаг. 2018 оны байдлаар ХасБанк нь Триодос-н хувьд зээлийн эх үүсвэр болон өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын аль алианаар нь санхүүжилт авсан харилцагч юм.



Cargill нь Миннесотад байршилтай дэлхийн хэмжээний хувийн корпораци бөгөөд хоол хүнс, хөдөө аж ахуй, санхүүгийн салбарын үйлдвэрлэлыг болон хэрэглэгчдийг ойртуулах замаар тогтвортой байдлыг хангах явдал юм. Cargill болон ХасБанк нь 2016 онд ОУСК-с олгосон хамтын зээлийн зээлдэгч болсон бөгөөд ХасБанк нь Cargill-с эх үүсвэр болон худалдааны санхүүжилт авдаг.



CaixaBank, S.A бол Иберийн хойгын улсуудын иргэдийн банкны салбарт тэргүүлэгч санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг групп юм. CaixaBank олон улсын банк (CIB) нь дэлхийн хэмжээнд өргөн сүлжээтэй бөгөөд үйл ажиллагааны хоёр тулгуур гол багана нь гадаад худалдаа, олон улсын төлбөр тооцооны бүтээгдэхүүнүүдийг санал болгодог ба үүндээ орон нутгийн санхүүгийн байгууллаар дамжуулж үйлчилгээ явуулдаг. ХасБанк нь 2017 оноос хойш хэрэглэгчиддээ богино хугацааны худалдааны санхүүжилтийг тогтмол олгож байна.



Олон улсын хөрөнгө оруулалтын банк ("IIB") нь гишүүн орнуудынхаа нийгэм, эдийн засгийн хөгжил, хөгжил цэцэглэлт, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх олон талт байгууллага юм. IIB нь ХасБанкинд 2016 онд ОУСБ-ийн хамтын зээлээр эх үүсвэр олгосон.



ResponsAbility Investment AG ("ResponsAbility") нь бие даасан, хөгжингүй эдийн засгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр мэргэшсэн, дэлхийд тэргүүлэгч хөрөнгийн удирдлагын компани юм. ResponsAbility нь ихэвчлэн хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компаниудад зээл болон үндсэн хөрөнгийн санхүүжилт олгодог. ResponsAbility нь одоогоор ХасБанк-д бичил, жижиг бизнес мөн байгальд ээлтэй бизнесийг дэмжих зорилгоор эх үүсвэр олгоод байна.



Хөгжиж буй дэлхийн зах зээл ("DWM") нь АНУ-д суурилсан хөрөнгө оруулалтын удирдлагын компани бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлтэй зөвхөн хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг байгууллага юм. 2018 онд ХасБанк DWM-ийн удирддаг Европын хөрөнгө оруулалтын сангуудтай байгуулсан зээлийн өр төлбөрөө дахин санхүүжүүлэх ажлыг амжилттай хийж 4.6 сая долларын шинэ эх үүсвэр татаад байна.



Инкофин хөрөнгө оруулалтын удирдлагын компани (Инкофин ХОУ) нь хөгжиж буй орнуудын бичил санхүүгийн бизнесийг дэмждэг хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөгөө өгдөг байгууллага юм. Бичил санхүүгийн бизнесүүд нь банк тогтмол хүрж ажиллах боломжгүй хүмүүс, хувиараа бизнес эрхлэгч нарт зээл, хадгаламж, даатгалын зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Инкофин ХОУ нь бичил санхүүгийн чиглэл түнчлэн хөдөө аж ахуйн санхүүжилтээр мэргэшсэн бөгөөд гол зорилго нь алслагдмал орон нутагт амьдардаг, мөн хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй ажилладаг хүмүүст хүрч дэмжлэг үзүүлэх явдал юм.



BlueOrchard нь дэлхийн нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын тэргүүлэгч менежер бөгөөд хөгжиж буй болон зах зээлд хүртээмжтэй, уур амьсгалын ухаалаг өсөлтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг дэмждэг. BlueOrchard компани өнөөдрийг хүртэл дэлхийн 80 гаруй оронд 6 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. BlueOrchard өөрийн сан, MIFA, BOFA-гийн сангаар дамжуулан ХасБанкинд эх үүсвэр олгосон.



BlueOrchard нь дэлхийн нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын тэргүүлэгч менежер бөгөөд хөгжиж буй болон зах зээлд хүртээмжтэй, уур амьсгалын ухаалаг өсөлтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг дэмждэг. BlueOrchard компани өнөөдрийг хүртэл дэлхийн 80 гаруй оронд 6 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. BlueOrchard өөрийн сан, MIFA, BOFA-гийн сангаар дамжуулан ХасБанкинд эх үүсвэр олгосон.



Дэлхийн цаг уурын түншлэлийн сан ("GCPF") нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар Германы Холбооны засгийн газрын санаачилгаар хаалттай санхүүжүүлтийн хэлбэрээр байгуулсан хөрөнгө оруулалтын сан юм. GCPF сан нь орон нутгийн санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчид болон хувийн өрхүүдэд чиглэсэн хугацаагүй хүлэмжийн хийг бууруулах төслийг санхүүжүүлдэг.



Швейцарийн хөрөнгө оруулалтын сан ("SIFEM") нь Швейцарын засгийн газрын 2005 онд байгуулагдсан хөгжиж буй орнуудыг дэмжих зорилттой санхүүгийн байгууллага юм. SIFEM нь ажлын байр бий болгож буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөгжиж буй орнуудад урт хугацааны, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Тус санг 2016 оноос хойш ХасБанктай амжилттай хамтран ажиллаж, идэвхитэй харилцааг бий болгосон хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх Obviam удирддаг.

Хүний нөөц



Ажилтны статистик:	
Нийт ажилтны тоо;	1270;
Гэрээгээр ажилладаг ажилтны тоо;	1481
Урт хугацааны чөлөө;	211
Төв албаны ажилтны тоо;	407
УБ хотын салбарын ажилтны тоо;	469
Орон нутгийн салбарын ажилтны тоо;	394
Дээд болон дунд шатны гүйцэтгэх удирдлага;	13+132
Эрэгтэй ажилтан;	471
Эмэгтэй ажилтан;	799
Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан;	9
Сургалтанд хамрагдсан ажилтны тоо;	1597
Нийт сургалтын хүн/цаг;	47342.5
Сургалтын хөрөнгө оруулалт;	1,022,787,685
Шинээр ажилд авсан ажилтны тоо;	238
Ажил горилогчийн тоо;	1450
Ажилтны дундаж нас;	31.4
Ажилтны дундаж ажилласан хугацаа;	6.4

Манай банкны хүний нөөцийн бодлого нь олон талт ур чадвар бүхий, аюулгүй, хүртээмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс олгох, ажил эрхлэлтийн шударга арга барилаар ажиллах, сурч хөгжих боломжийг ажилтан бүрд олгох зэрэгт чиглэдэг. Бид төрөл бүрийн нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж ажиллахад тууштай байр суурийг баримталдаг.

2018 оны эцсийн байдлаар, манай банк 1270 үндсэн ажилтантай байсан ба өмнөх онуудтай харьцуулбал 2017 онд 1304, 2016 онд 1304 ажилтантайгаар тус тус ажилласан.

Ажилтнуудын дундаж нас 31.4 бол ХасБанканд ажилласан дундаж хугацаа 6.4 жил байна. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагын дагуу 2018 оны туршид нийт 211 ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 90 ажилтан ажилдаа эргэн томилогдсон.

ОНЦЛОХ НЬ

2018 онд тууштай, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд ажилтнуудынхаа харилцагчдад чанартай үйлчилгээг шилдэг шийдлийн хамт үзүүлэх ур чадварыг сайжруулах, бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Дунд шатны менежерүүд, салбарын захирлууд болон чухал албан тушаалын ажилтнуудын бүтцийг олон талт ур чадвар бүхий бүтцээр төрөлжүүлэхэд өндөр ач холбогдол өгсөн ба түүнчлэн шинэ залуу чадварлаг ажилтнуудаа залгамжийн хөтөлбөрт хамруулан ур чадварыг нь хөгжүүлэхэд анхаарч ажиллаа.

Олон улсын сайн туршлага болон дотооддоо туршигдсан агуулга бүхий тусгайлсан сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан салбар, тооцооны төвийн нийт ажилтнуудыг албан тушаал бүрээр сургалтад хамрууллаа. Түүнчлэн бизнесийн болон хяналтын чиг үүрэг бүхий ажилтнуудыг төслийн санхүүжилтийн ахисан түвшний олон улсын сургалтад хамруулж ажиллаа. Дээд болон дунд түвшний удирдах ажилтнуудаа олон улсын манлайлал болон менежментийн сургалтын хөтөлбөрт хамруулж, амжилттай хамрагдсан удирдах ажилтнууддаа олон улсын сертификат гардуулах ажлыг зохион байгуулав.

Зээлийн үйл ажиллагааны шинэчлэгдсэн бодлого журмууд болон хянан нийцүүлэлт, үйл ажиллагааны эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын өргөтгөсөн агуулга бүхий онлайн сургалт болон мэдлэг шалгах шалгалтын ажлыг амжилттай зохион байгуулж нийт ажилтнуудаа хамруулав.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ҮР АШИГ БҮХИЙ ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бид 2017 онд шинээр батлагдсан эрсдэлийн тогтолцооны дагуу банкны бүх нэгжүүдийн чиг үүргүүдийг дахин зохион байгуулсан бол 2018 онд дунд хугацааны цахимжуулалт болон автоматжуулалтын стратегийн зорилтуудыг уялдуулан төв албан болон салбар тооцооны төвүүдийн чиг үүргүүдийн дахин зохион байгуулж үр ашиг бүхий оновчтой зохион байгуулалтын бүтцэд шилжлээ.

Түүнчлэн банкны нийт ажилтнууд хянан нийцүүлэлт, мөнгө угаах, мэдээлэл болон компьютерын аюулгүй байдал, үйл ажиллагааны эрсдэл болон харилцагчийн хамгаалах онлайн сургалтуудад хамрагдах үүргээ биелүүллээ.

Төв алба болон салбарын оновчтой бүтэц
Банкны үйлчилгээний автоматжуулалт болон дижитал банкны үйлчилгээний тэлэлтийн хүрээнд банкны ажилтнуудын бүтээмж нэмэгдэж, зарим чиг үүргүүд автоматчилагдсантай холбоотой банкны төв алба болон салбарын оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болголоо. Энэхүү зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд зарим нэгж, зарим албан тушаалуудын чиг үүргүүд дахин зохион байгуулагдаж, улмаар банкны ажиллах хүчний тоо 10 хувиар буурсан. Шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалт нь банкны ажилтнуудын бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зардал бууруулах ач холбогдолтой.

АЖИЛ АМЬДРАЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ

Банк ажилтнуудынхаа ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, хамгийн багадаа ажлын 10 өдөр ажил үүргээсээ хөндийрөх бодлогыг сүүлийн хоёр жилийн хугацаанд баримталж ирсэн ба өнгөрөгч онд ажилтан бүрийн ажилласан хугацаанаас хамааран Хөдөлмөрийн хуулийн дагуу олгогдож буй ээлжийн амралтаа бүтэн авахыг шаардсан ба ингэснээр өмнөх оныхтой харьцуулахад 300 хүн/өдрийн илүү ээлжийн амралтын хоногийг олгосон.

Ээлжийн амралттай байх хугацаандаа ажилтан өөрийн биеэр болон цахим хэлбэрээр үндсэн үүргээ гүйцэтгэхгүй байх үүрэгтэй.

Энэхүү бодлогыг чанд мөрдөн хэрэгжүүлснээр банк эрсдэлийн удирдлагын бодлогоо дагаж мөрдөх болон ажилтанд бодит хангамж үзүүлэх буюу ажилтан ажил үүргээсээ тодорхой хугацаагаар холдох, амарч, ажиллах эрч хүчээ сэлбэх, ажилтнуудын эрүүл мэнд, ажил амьдралын тэнцвэрт байдал, сайн сайхан оршихуй, ажлын гүйцэтгэл зэрэгт чухал ач холбогдолтой гэж үздэг.

ОЛОН ТАЛТ, ХҮРТЭЭМЖТЭЙ АЖИЛЛАХ ОРЧИН

Олон талт мэдлэг, ур чадвар, туршлага бүхий ажилтнуудаас бүрдсэн баг маань банкны өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, нэмэгдүүлэх, харилцагчийн бодит эрэлт, хэрэгцээнд нийцсэн банкны үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэдэгт бид итгэдэг.

Олон талт ур чадвар: Банк дээд болон дунд түвшний удирдах ажилтнуудаа аль болох олон талт ур чадвар бүхий өөр өөр мэргэжил, мэдлэг, туршлага бүхий хөдөлмөрийн зах зээл дээрх хамгийн өндөр ур чадвар бүхий мэргэшсэн мэргэжлийн экспертүүдээр бүрдүүлэхийг зорьж ажилладаг. Харин 2018 онд, банканд ажиллаж буй шинэ залуу чадварлаг ажилтнуудынхаа ур чадварыг хөгжүүлэх, дараа дараагийн залгамж ажилтнуудаа бэлтгэхэд түлхүү анхаарсан жил байлаа. Тухайлбал, банк дотроо болон монголын хөдөлмөрийн зах зээлд туршигдсан агуулга бүхий салбарын захирал бэлтгэх залгамжийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүллээ.

Хүний нөөц

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд өнгөрөгч онд 10 салбарын захирал, 9 газар, хэлтсийн захирлын албан тушаалд залуу чадварлаг ажилтнуудаа дэвшүүлэн томиллоо.

Нийтдээ, банкны дээд болон дунд түвшний удирдах ажилтнуудын 71.2% нь банкин дотроо албан тушаал дэвшсэн бол 25.6% нь өрсөлдөгч банк болон санхүүгийн байгууллагаас, 2.4% нь олон улсын байгууллагаас, 0.8% нь гадаад ажилтнууд бүрдүүлж байна.

Үр дүн бүхий оутсоринг: 2018 онд банк, анхан шатны буюу үйлчилгээний ажилтнуудыг бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг туршлага бүхий гадны байгууллагаар хийлгэх ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж, туршсан. Энэхүү туршилтын үйл ажиллагааны хүрээнд хүний нөөцийн мэргэжилтнүүдийн 200 хүн/өдрийн ажил буюу дийлэнхдээ бүрдүүлэлтийн аян, ажил горилогчдын анкет хүлээж авах, сонгон шалгаруулах зэрэгт зарцуулагддаг байсан цаг хугацааг хэмнэж чадсан.

Түүнчлэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, сайтар туршигдсан, батлагдсан сонгон шалгаруулалтын арга хэрэгслийг ажил горилогчийн зан төлөвийн онцлог, хандлагад тулгуурлан шалгаруулж эхэлсэн. Өнгөрөгч онд нийт 220 ажил горилогч болон дотооддоо шилжилт хөдөлгөөн хийсэн ажилтнуудад дээрх сонгон шалгаруулалтын арга хэрэгслийг ашигласан.

ЦАЛИН ХӨЛС, ХАНГАМЖ

Өнгөрөгч 2018 онд банк нийт ажилтнуудынхаа үндсэн цалинг шинэчлэгдсэн албан тушаалын зэрэглэл болон цалингийн системийн дагуу дунджаар 10 хувиар нэмэгдүүлсэн. Шинэчлэгдсэн цалингийн системийн дагуу өндөр үр чадвар бүхий ажилтнууд банкны бизнест оруулж буй хувь нэмрээс хамаарч удирдах албан тушаалтан, дунд түвшний удирдах ажилтантай ижил тэгш хэмжээнд үнэлэгдэх боломжтой болсон. Түүнчлэн шинэчлэгдсэн цалингийн системийг ажилтнуудад таниулах, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгууллаа.

Богино хугацааны шагнал урамшуулал: Хувьсах цалин хөлс нь ололт амжилтыг хувь хүн, баг, байгууллагын түвшинд үнэлж, урамшуулахад чиглэсэн бөгөөд дээрээс доош чиглэсэн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдээр хэмжигддэг. 2017 оны банкны ашиг, үр дүнд үндэслэн нийт ажилтнуудад жилийн урамшууллыг ажлын гүйцэтгэлийн зорилтын биелэлттэй нь харьцуулан тооцож олгосон.

Урт хугацааны шагнал урамшуулал: Тэтгэврийн нэрийн дансны үйл ажиллагааны бодлого, журмыг шинэчлэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаар танилцуулан батлуулах ажлыг зохион байгуулсан ба банкны бүх ажилтнуудад шинэчлэгдсэн хэлбэрээр тусгай хадгаламжийн бүтээгдэхүүнтэй ижилхэн байдлаар танилцуулагдсан.

АЖИЛТНУУДЫН ХӨНГӨЛӨЛТ ХАНГАМЖ, САЙН САЙХАН ОРШИХУЙ

ХасБанк нь ажилтнуудынхаа сайн сайхан оршихуйг хангаж ажиллах тууштай байр суурийг хадгалж ирсэн бөгөөд ажилтнуудын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн олон төрлийг нийгмийн хангамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн.

Банкнаас эрүүл мэндийн даатгал, хувийн тэтгэврийн хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж, ажилтнуудынхаа санхүүгийн баталгааг хангаж ажилладаг. Өнгөрөгч 2018 онд ажилтнуудын тэтгэврийн нэрийн дансыг банкны үндсэн системд харилцагчийн тусгай нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүнтэй ижил хэлбэрт шинэчлэгдсэн журмын дагуу шилжүүлсэн.



Нийт ажилтнууд банкны тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ба урт хугацаат хадгаламжийн хэлбэртэй уг хөтөлбөрийн хүрээнд ажилтны төлсөн шимтгэлтэй ижил хэмжээний мөнгийг ажил олгогчоос төлж, хуримтлуулж байна. Түүнчлэн, орон сууцны зээл, хэрэглээний зээл, зээлийн карт зэрэг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр ажиллагсдадаа үзүүлж байна.

2018 онд давхардсан тоогоор 2800 гаруй ажилтнууд сайн сайхан оршихуйн хөтөлбөрт хамрагдсан.

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Байгууллагын өсөлт, хөгжил нь ажилтнуудын сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдтэй салшгүй уялдаатай байдаг. Тиймээс банк олон төрлийн сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлдэг. Өнгөрөгч 2018 онд олон улсын түвшний гадаад болон гадны сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд болон олон улсын мэргэжлийн зэрэг, сертификат олгох хөтөлбөрүүд болон нийт салбар, тооцооны төвийн бүх ажилтнуудыг сургаж, шаардлагатай үр чадваруудыг нь хөгжүүлэхэд голчлон анхаарч нийт 47,342 хүн цагийн сургалт, хөгжлийн хөтөлбөрийг амжилттай зохион байгууллаа. (2017 онд 53,178 хүн/цаг 2016 онд 47,644 хүн/цаг).

Иргэдийн банкны сургалт:

Иргэдийн банк тэр дундаа салбар, тооцооны төвийн ажилтнуудыг сургах, хөгжлийн хөтөлбөрт хамруулах нь өнгөрөгч онд тэргүүлэх чиглэл байв. Өссөн дүнгээр 35.409 хүн цагийн сургалтад 940 гаруй салбар, тооцооны төвийн ажилтнуудыг хамрууллаа.

- Найман сарын туршид зургаан модуль сургалтаас бүрдсэн салбарын захирлын залгамж бэлтгэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.
- Улаанбаатар хотын болон орон нутгийн салбар, тооцооны төвийн нийт 294 зээлийн мэргэжилтнүүд болон хувийн банкируудад зориулсан зээлийн сургалтыг шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалт болон журам зааврын хүрээнд зохион байгууллаа.
- Ахисан түвшний зээлийн шинжилгээ, төслийн санхүүжилтийн сургалтыг борлуулалтын болон хяналтын чиг үүрэг бүхий ажилтнуудад 2018 оны наймдугаар сард зохион байгуулсан.
- Өнгөрөгч оны 3-8 сард нийт салбар, тооцооны төвүүдийн теллерийн болон хувийн үйлчилгээний ажилтнуудыг шинэчлэгдсэн харилцагчийн үйлчилгээ болон борлуулалтын сургалтын хөтөлбөрийн дагуу нийт 221 ажилтанд 8600 хүн/цагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.
- Шинээр банканд орж буй нийт 61 теллерийн албан тушаалын ажилтнуудыг хоёр өдрийн шинэ ажилтны чиглүүлэх, арван өдрийн харилцагчийн үйлчилгээ, таван өдрийн банкны программ хангамжийн сургалтад гурван удаа хамрууллаа.



- Түүнчлэн салбар хооронд туршлага, мэдлэг хуваалцах уулзалт семинарыг тогтмол зохион байгуулж нийт 8.453 хүн/ цагийг зарцуулсан.

Эрсдэлийн удирдлага, хянан нийцүүлэлтийн сургалт:

Банк 2016 онд нэвтрүүлсэн Хянан нийцүүлэлтийн цахим сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, 2016 онд 1,000 гаруй ажилтан хамрагдаж байсан бол 2017 онд 142 ажилтан, 2018 онд 119 ажилтныг тус тус хамрууллаа.

Шинэчлэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог таниулах, өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгох, шинэчлэгдсэн бодлого журмыг ажилтнуудад таниулах, мөрдлөг болгох зэрэгт дотоод сургалт, семинар болон ажилтнуудын дотоод цахим хуудас зэргийг өргөнөөр ажиллаж байна.

Өнгөрөгч 2018 онд банкны бүх ажилтнуудын эрсдэлийн удирдлага болон хянан нийцүүлэлтийн мэдлэг, хэрэглээг өргөжүүлэх зорилгоор нийт ажилтнуудад онлайн сургалт болон мэдлэг шалгах шалгалтыг зохион байгуулсан ба мэдлэг шалгах шалгалтын дундаж оноо 92% байв. Түүнчлэн шинэчлэгдэн батлагдсан зээлийн үйл ажиллагааны бодлого, журмын хэрэгжилтийг бататгах, хянах зорилгоор зээлийн үйл ажиллагаанд оролцогчдоос онлайн шалгалт авах ажлыг зохион байгууллаа.

Мөн иргэдийн банк, салбар тооцооны төвүүдийн ажилтнуудын сургалтын хөтөлбөрт эрсдэлийн удирдлагын агуулгыг тогтмол оруулж ирсэн.

Менежмент болон манлайллын сургалт

2018 онд банкны гүйцэтгэх удирдлагын санаачилгын хүрээнд ХБНГУ-ын Франкфуртын Санхүү менежментийн сургуулийн сургагч багш хатагтай Үтэгийн олон улсад сайтар туршигдсан Менежмент болон манлайллын гурван модуль 64 хүн/цагийн сургалтыг дээд болон дунд түвшний удирдах ажилтнууддаа 6-10 саруудад амжилттай зохион байгуулав.

Мэдээллийн технологийн сургалт

Өнгөрөгч онд 3.950 хүн/цагийн сургалтад мэдээллийн технологийн 60 гаруй ажилтныг амжилттай хамрууллаа. Түүнчлэн банк мэдээллийн технологийн ажилтнуудаа олон улсын мэргэжлийн зэрэг авах, олон улсын түвшинд ажиллах чадвар олгох сургалтуудад хамруулахад голчлон анхаарч ажилласан ба үүний үр дүнд хоёр ажилтан олон улсын мэргэжлийн сертификатыг гардан авлаа.

Түүнчлэн бусад онцлог сургалтуудыг дурдвал:

- Нийт таван ажилтан COBIT 5 олон улсын онлайн сургалтад амжилттай хамрагдаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификатаа гардан авсан;
- Administering System Center Configuration Manager болон MCTS Windows сургалтуудад тус бүр дөрөв, дөрвөн ажилтнаа хамруулсан;
- АНУ-ын Лас Вегас хотод зохион байгуулагдсан Dell Technologies World 2018 хуралд хоёр ажилтнаа оролцуулсан.
- Мэдээллийн технологийн ахисан түвшний аюулгүй ажиллагааны сургалтад арав гаруй ажилтан, түүнчлэн QA and QTP/UFT- ийн нийт 1534 хүн/цагийн сургалтад 26 ажилтнаа тус тус хамруулсан;

Дотоод аудитын сургалт

Өссөн дүнгээр 136 хүн/цагийн сургалтад 11 аудиторыг хамруулсан ба Мэдээллийн технологийн нэг аудитор олон улсын CISA буюу мэргэшсэн мэдээллийн технологийн аудитор сертификатаа амжилттай гардан авав. Түүнчлэн хэд хэдэн аудиторууд мэргэшсэн дотоод аудиторын шалгалтуудыг амжилттай өгсөн.

АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

Бид ТэнГэр санхүүгийн нэгдлийн хэмжээнд ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн засаж сайжруулах шаардлагатай зүйлсээ тодорхойлдог.

2018 онд сэтгэл ханамжийн судалгааг Gallup-ийн ажилтнуудын оролцооны санал асуулгыг ашиглан амжилттай зохион байгууллаа. Судалгаанд ажилтнууд 81.7 хувийн идэвхтэй оролцож (2017 онд 81.6 хувь байсан), сэтгэл ханамжийн индекс 79.7 хувьтай гарлаа (2017 онд 78.4% байсан).

АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО

Ажилтнуудын оролцоо бол ХасБанк төдийгүй ТэнГэр санхүүгийн нэгдлийн хувьд тэргүүлэх гол чиглэл байсаар ирсэн.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ТэнГэр санхүүгийн нэгдлийн бүх ажилтны баярын хурал, удирдах ажилтнуудын зөвлөгөөн, ажилтнуудын дотоод цахим сүлжээ, тогтмол хийгддэг цахим уулзалт, хурал болон удирдлагын багийн жил бүр Улаанбаатар хотын болон орон нутгийн бүх салбар, тооцооны төвийн тойрон айлчлал, албан томилолт, банкны нэгжүүдийн хурал зөвлөгөөн, стратегийн хэлэлцүүлэг, гүйцэтгэлийн үнэлгээний уулзалтууд зэрэг арга хэмжээнүүдээр дамжуулан ажилтнуудын оролцоог хангаж байна.

Компанийн нийгмийн хариуцлага



Соёлын өвийг хамгаалах

Тархан суурьшсан Монголчууд ТББ-ын Эзэнт гүрний соёрхолт өв 3 боть номыг бүтээхэд дэмжиж байна.

Нэрт эрдэмтэн, зохиолч Бямбын Ринчений 5 боть бүтээлийн дээжийг хэвлэлээ.

“Улаанбаатар” олон улсын медиа урлагийн наадмыг 3 дахь жилдээ ивээн тэтгэлээ.

ЕБС-уудын дунд зохион байгуулсан “Монгол бахархал – Цагаан сар” тэмцээнийг ивээн тэтгэж, хүүхэд залууст ёс заншил, өв уламжлалаа танин мэдэхэд хувь нэмэр орууллаа.



Урлагийг дэлгэрүүлэх

Монголд анх удаа зохион байгуулагдсан The Voice of Mongolia шоу нэвтрүүлгийг дэмжин хамтран ажиллалаа. Авьяаслаг Монголчууд нэвтрүүлгийг 3 дахь жилдээ ивээн тэтгэлээ.

Хүүхдүүдэд соёлын өвийн болон урлагийн боловсрол олгох “Миний мөрөөдөл” төслийг амжилттай хэрэгжүүллээ.

Мөрөөдлөө зураг баримлаар дүрслэх чиглэлээр 100 гаруй хүүхдэд сургалт явуулж, 3-14 насны багачуудын дунд бүтээлийн уралдаан зохион байгууллаа.

МҮОНТ-ийн “Эрт нахиалсан сарнай” 30 ангит УСК-г бүтээхэд дэмжлэг үзүүллээ.



Спортыг хөгжүүлэх

Байт харвааны 360 талбайг барьж байгуулах хувь нэмрээ орууллаа.

Дуулиан 2020 заалны хөлбөмбөгийн тэмцээнийг 12 дахь жилдээ дэмжин, 5 сургуулийн 40 багийг ивээн тэтгэж оролцууллаа.

Хасын хүлэгүүд сагсан бөмбөгийн баг 6 дахь удаагаа лигийн аварга боллоо.

Хас мэргэжлийн дугуйн клубийн тамирчид маань дотоодын болон ОУ-ын тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож, эх орныхоо нэрийг гаргаж байна.

Монголын Байт харвааны холбоо, Монголын Хонхтой Бөмбөгийн холбоодыг ивээн тэтгэж, Улсын аваргын тэмцээнээ зохион байгуулах, ОУ-ын тэмцээнд оролцоход нь дэмжлээ.



Боловсрол, эрүүл мэндийг дэмжих

Санхүүгийн боловсрол олгох Афлатон хөтөлбөр 10 сургуулийн 140 багш, 5160 хүүхэд, түүний дотроос 230 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрлээ.

Шилдэг илтгэгчдийг нэг дор цуглуулсан TEDxUlaanbaatar арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллалаа.

ХасБанкны 1400 гаруй ажилтнаа ханиад томууны эсрэг вакцинд хамрууллаа.

Тэнгэр даатгал компанитай хамтран ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулж байна.

Эх дэлхий

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

ЭХ ДЭЛХИЙ

ЭРҮҮЛ АШИГ

Эко Банк

Байгаль Орчны Хариуцлага

Тогтвортой шийдлүүдийг нэвтрүүлэх нь



Карбоны ялгарлыг бууруулах зорилгоор ХасБанк нь төсөл хөтөлбөр болон зээлийн бүтээгдэхүүнээр дамжуулан бодит шийдлүүдийг нэвтрүүлж ажиллаж байна. Бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь олон улсад тулгамдаж буй асуудлуудыг тогтвортой хөгжил бий болгох замаар шийдэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилготой нийцэж байгаа юм.



Нийгэм болон хамтрагч байгууллагуудын байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглүүлэх

Бид байгууллагын нийгмийн хариуцлага болон урт хугацааны тогтвортой хөгжлийг үндэс болгон Нийгэм болон Байгаль Орчны Бодлогыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

ХасБанк нь тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд банкны үйл ажиллагааны экологи болон нийгэмд үзүүлэх нөлөөг хянах зорилгоор 2002 оноос эхлэн ISO 14001 стандартын дагуу Байгаль Орчин Нийгмийн Хариуцлагын Эрсдэлийн Үнэлгээг (БОНХЭҮ) нэвтрүүлсэн билээ. ХасБанкны нийт ажилчид БОНХЭҮ-ний талаар сургалтад хамрагдаж, зээл олголт, худалдан авалт зэрэг банкны үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байгаа ба тус үнэлгээг 2008, 2011, 2014, 2018 онуудад шинэчилсэн болно.

ХасБанк нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2018 онд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж ажилласан:

- Ногоон Санхүүжилтийн Хоёрдугаар Чуулганыг “Эрчим Хүчний Хэмнэлтийг Дэмжье” уриан доор зохин байгуулж, ЖДБ болон бусад оролцогчид талуудаас бүрдсэн нийт 400 гаруй зочдыг хамруулсан. Форумгаар дамжуулан УАНС-тай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн Хийг Бууруулах Зорилгоор Олгогдох Бизнесийн Зээлийн талаар мэдээлэл өгөн, эрчим хүчний хэмнэлттэй шийдэлд хөрөнгө оруулахын ач холбогдлыг онцолсон болно.

- УАНС-гийн Үндэсний Эрх Бүхий Байгууллагын Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд 18 сургалтад 783 хүн хамруулсан.
- Төрийн болон хувийн хэвшлийн 600 гаруй зочид төлөөлөгчид оролцсон Үндэсний Сэргээгдэх Эрчим Хүчний 9-р чуулганд оролцож Монгол улсын эрчим хүчний бодлогын талаарх хэлэлцэж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг дэмжих талаарх хэлэлцсэн.
- Банкны харилцагчдын чадавхи бэхжүүлэх зорилгоор Эко Банкны Хэлтэс нь нягтлан бодохын чиглэлд зургаа, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний талаар гурван сургалт зохион байгуулж нийт 224 харилцагч ЖДБ-ийг хамруулсан.
- “UNEP-DTU” байгууллагын Олон улсын технологийн хэрэглээний үнэлгээний сургалтад ХасБанк үндэсний технологийн хэрэглээний үнэлгээнд тулгуурлан уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх төсөл хөтөлбөр боловсруулан санхүүжилт босгох талаар сургалт орсон.
- ХасБанк, Мерси Кор Олон Улсын байгууллага, Тэнгэр Даатгалын хамтран хэрэгжүүлж буй Ногоон бэлчээрийн төслийн зээлийг хөтөлбөрийг нээлтийг Хэнтийн аймгийн Баян-Овоо суманд 2018 оны 12-р сард зохион байгуулж, орон нутгийн удирдлагуудад бэлчээрийн чанарыг сайжруулах замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад амьжиргааг нь тогтвортой болгох зорилгоор олгогдох хөнгөлөлттэй зээлийн талаар танилцуулсан юм.

Ногоон санхүүжилтийн санаачилга

ХасБанкны Эко банкны хэлтэс нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тогтвортой санхүүжилт хийх, бизнесийн үйл ажиллагааны эрчим хүчний хэмнэлтийг тооцох, хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох чиглэлээр мэргэшин ажиллаж буй Монгол улсын банкны систем дэх цорын ганц банкны нэгж юм. Эко банкны хэлтэс нь Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Карбоны санхүүжилт, Тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийх гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.



Хэрэгжүүлэлж буй төсөл, хөтөлбөр

Эко банкны хэлтсийн үйл ажиллагаа нь Ногоон зээлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг өргөжүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах, өмнөх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хяналт тавих, мөн ногоон санхүүжилтийн хүрээнд чадавх бэхжүүлэхэд чиглэсэн байдаг.

2018 онд ХасБанкны Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн гурав дахь жил тохиож байна. Хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулан санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтууд, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан ногоон зээлийг тодорхойлох талаар сургалтууд, мөн ногоон зээлийг тодорхойлох ажлыг хялбарчлах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй технологийн жагсаалт боловсруулах, Бизнес эрхлэгч нарт зориулан жил бүр Ногоон санхүүжилтийн форумыг уламжлал болгон зохион байгуулах зэрэг ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

2018 оны онцлох үйл явдлын нэг нь УАНС-ын Үндэсний Эрх Бүхий Байгууллага, Байгаль орчин аялал жуулчлалын яамны Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн явдал байлаа. Энэ хүрээнд Үндэсний эрх бүхий байгууллагын уур амьсгалын санхүүжилтийн чадавхыг бэхжүүлэх, УАНС-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлууд амжилттай хийгдсэн.

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:

- 2010-2015:** Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын өрхийн 80 орчим хувьд ХасБанкны бүтээгдэхүүн борлуулалтын цэгээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг татаастай үнээр борлуулсан.
- 2017-2018:** Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд чадавх бэхжүүлэх, хөтөлбөрийг олон нийтэд таниулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2018 онд 240 харилцагч, 220 зээлийн мэргэжилтнийг эрчим хүчний хэмнэлтийн талаарх сургалт, семинарт хамруулаад байна.

- 2018:** ХасБанк нь Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд энэ хүрээнд нийт 18 сургалт, семинарыг амжилттай зохион байгуулсан. Ингэснээр Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт оролцогч талуудын дунд нэмэгдэж, Үндэсний хөтөлбөрийг нийтээр хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ.
- 2018:** 10МВт-ын хүчин чадалтай Сүмбэр нарны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэхэд хяналт тавин ажиллав.

Ногоон санхүүжилтийн санаачилга

ХасБанкны Эко банкны хэлтэс нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тогтвортой санхүүжилт хийх, бизнесийн үйл ажиллагааны эрчим хүчний хэмнэлтийг тооцох, хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох чиглэлээр мэргэшин ажиллаж буй Монгол улсын банкны систем дэх цорын ганц банкны нэгж юм. Эко банкны хэлтэс нь Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Карбоны санхүүжилт, Тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийх гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр

Эко банкны хэлтсийн үйл ажиллагаа нь Ногоон зээлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг өргөжүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах, өмнөх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хяналт тавих, мөн ногоон санхүүжилтийн хүрээнд чадавх бэхжүүлэхэд чиглэсэн байдаг.

2018 онд ХасБанкны Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн гурав дахь жил тохиож байна. Хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулан санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалтууд, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан ногоон зээлийг тодорхойлох талаар сургалтууд, мөн ногоон зээлийг тодорхойлох ажлыг хялбарчлах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй технологийн жагсаалт боловсруулах, Бизнес эрхлэгч нарт зориулан жил бүр Ногоон санхүүжилтийн форумыг уламжлал болгон зохион байгуулах зэрэг ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

- 2018 оны онцлох үйл явдлын нэг нь УАНС-ын Үндэсний Эрх Бүхий Байгууллага, Байгаль орчин аялал жуулчлалын яамны Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн явдал байлаа. Энэ хүрээнд Үндэсний эрх бүхий байгууллагын уур амьсгалын санхүүжилтийн чадавхыг бэхжүүлэх, УАНС-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлууд амжилттай хийгдсэн. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:
- 2010-2015: Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын өрхийн 80 орчим хувьд ХасБанкны бүтээгдэхүүн борлуулалтын цэгээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг татаастай үнээр борлуулсан.
 - 2017-2018: Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд чадавх бэхжүүлэх, хөтөлбөрийг олон нийтэд таниулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2018 онд 240 харилцагч, 220 зээлийн мэргэжилтнийг эрчим хүчний хэмнэлтийн талаарх сургалт, семинарт хамруулаад байна.
 - 2018: ХасБанк нь Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд энэ хүрээнд нийт 18 сургалт, семинарыг амжилттай зохион байгуулсан. Ингэснээр Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт оролцогч талуудын дунд нэмэгдэж, Үндэсний хөтөлбөрийг нийтээр хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ.
 - 2018: 10МВт-ын хүчин чадалтай Сүмбэр нарны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэхэд хяналт тавин ажиллав.

Карбоны санхүүжилт

2018онд ХасБанкнаас Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүд авсан бүтээгдэхүүнээ хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих судалгаагаа үргэлжлүүлэв. Ингэснээр бид “МикроЭнержи Кредитс” компанитай хамтран карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон

Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн карбоны нөхөн олговор хүлээн авах боломж бүрддэг. Нэгж карбон кредит гэдэг нь нэг тонн нүүрстөрөгчийн ялгарлын бууралт гэсэн үг юм. Карбон кредитийг байгууллагын нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх гэж буй корпорацууд болон нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхээр зорьж буй улс орнуудад зарж борлуулах боломжтой байдаг. ХасБанкны карбон кредитийн голлох худалдан авагч нь Шведийн Засгийн газар, Микософт корпорац нар юм.

- Карбоны санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:
- 2009: Карбоны нөхөн төлбөрийг авч эхлэх зорилгоор МикроЭнержи компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
 - 2011: Төслийн хүрээнд бий болсон карбон кредитийг Нүүрстөрөгчийн сайн дурын зах зээлд бүртгүүлснээр анхны карбоны нөхөн төлбөр хүлээн авав.
 - 2013: Цэвэр хөгжлийн механизмд Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах төслүүдээ бүртгүүлснээр карбон кредитээ борлуулах боломж бүрдлээ.
 - 2015: ЭХХ-тэй бүтээгдэхүүн борлуулах төслийн үр дүнд бий болсон карбон кредитээ Шведийн Засгийн газарт худалдах гэрээ байгуулав.
 - 2016-2018: Төслүүдийн үр дүнд бий болсон карбон кредитийг Цэвэр хөгжлийн механизмд 2016 онд бүртгүүлснээс хойш нийт 300,000 карбон кредитийг бүртгүүлээд байна.

Тогтвортой Санхүүжилт

ХасБанк нь 2009 онд ЭкоБанкны хэлтсийг байгуулж, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласны үр дүнд бизнес эрхлэгчид болон иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний технологиудыг санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээл олгож ирсэн.

2018 оны хувьд Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2019 оноос эхлэн Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхээр зээлийн гэрээ байгуулаад байна.

- Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:
- 2009: Нидерландын Хөгжлийн Банкны (FMO) 6.5 тэрбумын төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр дамжуулан 1,778 айл өрхөд Эрчим Хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг хэрэглээний зээлээр олгосон.
 - 2012-2018: Бизнес эрхлэгчдэд зориулсан Эко зээл олгож эхэлснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, борлуулагчид, хэрэглэгчид эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй зээлээр дамжуулан худалдан авах боломж бүрдсэн.
 - 2012 онд Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас (GCPF) тогтвортой санхүүжилтийг дэмжих зорилгоор 20 сая ам долларын эх үүсвэр хүлээн авсан.
 - Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2013 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилт (МонСЭФФ)-ийн 10 сая ам долларын эх үүсвэр хүлээн авсан.

- 2017 онд Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн хүрээнд 19.5 сая ам долларыг зээлийн зориулалтаар, 500,000 ам долларыг хөтөлбөр хөгжүүлэлтийн зориулалтаар тус тус хүлээн авсан.
- 2013 оноос эхлэн нийт 111.9 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд олгож, хүлэмжийн хийн ялгарлыг 1,392,560 тонноор бууруулсан.
- 2014-2018: Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч РеспонсАбилити байгууллагатай хамтран Эко автомашины зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шатахууны зардлыг хэмнэх авто машиныг зах зээл дээрхээс бага хүүтэйгээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, 2018 онд хөтөлбөр дуусахад 1,067 харилцагчид 5.2 сая ам долларын санхүүжилт олгосон байна.



Уур Амьсгалын Ногоон Сан

Уур Амьсгалын Ногоон Сан нь хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор НҮБын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд байгуулагдсан юм. ХасБанк нь Монгол Улс дахь Уур Амьсгалын Ногоон Сангийн (УАНС) цор ганц магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага юм.

Уур Амьсгалын Ногоон Сан нь ХасБанкны тогтвортой санхүүжилтийн зорилтын хүрээнд хамгийн том хамтрагч байгууллага юм. 2018 оны хувьд ХасБанк УАНС-гийн удирдах зөвлөлд Хялбарчилсан батлах загвараар Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийн /SAP004/ төслийн саналаа батлуулах түншлэлээ үргэлжлүүллээ. 2018 оны сүүлээр ХасБанк, УАНС-тай хамтран санхүүжүүлсэн Сүмбэр нарны цахилгаан станцын барилгын ажил дууссан нь тус сангийн санхүүжилтээр хэрэгжсэн анхны төслийн санхүүжилт боллоо.

ХасБанк болон нь Уур Амьсгалын Ногоон Сангийн хамтын ажиллагааны хүрээнд онцлох үйл явдлууд:

- 2016: ХасБанк нь хөгжиж буй орнуудаас Уур Амьсгалын Ногоон Сангийн хамгийн анхны магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2016: FP 028: Хүлэмжийн Хийг Бууруулах Зорилгоор Олгогдох Бизнесийн Зээлийн хөтөлбөр нь Уур Амьсгалын Ногоон Сангаас зээлийн хүрээнд 19.5 сая ам доллар, хөтөлбөр хөгжүүлэлтийн хүрээнд 500,000 ам долларын санхүүжилт авахаар батлагдсан.

- 2018: Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр 9 сая ам.долларын зээл, 1 сая ам.долларын буцалтгүй тусламжийг УАНС-аас авах гэрээ байгуулаад байна. Уг зээлийн хөтөлбөрийг 2019 оны эхний улиралд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байна.
- 2018: ХасБанк нь Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран Ногоон бэлчээрийн төслийн зээлийг хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн гол зорилго нь малын тоог цөөлөх замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, малчдад хөнгөлттэй зээл олгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад амьжиргааг нь тогтвортой болгох юм.

- 2017: FP 028: Хүлэмжийн Хийг Бууруулах Зорилгоор Олгогдох Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн ХасБанк хүлээн авсан нь, УАНС-гаас төслийн саналын санхүүжилтийг бүрэн олгосон анхны тохиолдол боллоо.
- 2017: ХасБанкны хоёр дахь төслийн санал болох FP 046: Сэргээгдэх Эрчим Хүчний 1-р Хөтөлбөрийг УАНС-гаас 8.65 сая ам долларын санхүүжилт баталсан. Уг төслийн хүрээнд ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн анхны арилжааны банк болсон юм.
- 2018: ХасБанкны гурав дахь төслийн санал болох SAP004: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн хөтөлбөрийг Уур Амьсгалын Ногоон Сангаас зээлийн хүрээнд 9 сая ам доллар, хөтөлбөр хөгжүүлэлтийн хүрээнд 1 сая ам.доллараар санхүүжүүлэхээр баталсан. ХасБанк нь Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2018: ХасБанкнаас тавьсан хоёр дахь санхүүжилтийн саналын дагуу (2017 онд батлагдсан) Нарны цахилгаан станц баригдаж дуусаж Монгол улсын төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд эрчим хүч нийлүүлэхэд бэлэн боллоо.

2019 онд ХасБанк нь тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа УАНС-н төсөл бэлтгэх болон Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрүүдийн хүрээнд улам өргөжүүлэх зорилготой байна. Уг төслүүд нь банкны зүгээс харилцагчид болон хүрээлэн буй орчинд нэгэн зэрэг үйлчлэх боломжийг бий болгох юм.

Эрүүл ашиг

ЭРДЭНЭГ ХҮМҮҮН

ЭХ ДЭЛХИЙ

ЭРҮҮЛ АШИГ

Бизнесийн үйл ажиллагааны орчин

Жилийн турш үргэлжилсэн бизнесийн болон санхүүгийн мөчлөгийн тэлэлтийн үр дүнд оны сүүлчээр эерэг үр дүн гарсан. Эдийн засгийн бодит өсөлт нь 6.9% гарсан нь 2018 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалаас өндөр байсан бөгөөд үүнд эдийн засгийн гол салбарууд болох уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, бүтээгдэхүүний цэвэр татвар, тээвэр болон агуулахын үйлчилгээ, бөөний болон жижиглэнгийн худалдаа голлон нөлөөлсөн бөгөөд тус бүр 2.0, 1.2, 1.1, 1.0, 0.6, 0.5 болон 0.4 нэгж хувь байсан байна. Барилгын салбар -0.2 нэгж хувиар агшсан үзүүлэлтэй гарсан бөгөөд орон сууцны зээлийн эрэлт хэрэгцээ болон санхүүжилтийн эх үүсвэрийг зөрөөг оновчтой шийдвэрлэж чадсанаар барилгын салбарт эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм. 2018 оны 12 сарын байдлаар ажилгүйдлийн түвшин 0.7 нэгж хувиар өсч 6.6%-д, өрхийн дундаж орлого 15.4%-иар өсч 1.2 сая төгрөг болсон байна. Инфляцын нөлөөллийг тооцсон өрхийн бодит орлого, зарлага тус бүр харгалзан 13.6% болон 8.8%-иар өссөн боловч 2014 оны 4-р улирлаас хойш өрхийн бодит зарлага орлогоосоо өндөр байгаа тул дунд хугацаанд өрхийн өр байсаар байна.

АНУ нь засгийн газрын бондын өгөөж өсөлтгүй байсан, дэлхийн нийтийг хамарсан эдийн засгийн удаашрал, жишиг хүү өссөн, АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хурцадмал байдал, ам.долларын ханш голлох валютуудын эсрэг нилээд чангарсан гэх мэт хүчин зүйлс нь дунд хугацаан дахь гадаад хүчин зүйлийн нөлөөг өсгөсөн байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл байдал 2018 оны турш тогтвортой байж 0.2%- ийн өсөлттэй гарсан. Экспорт, импортын үнийн индекс тус бүр 11 гаруй хувиар өссөн үзүүлэлтэй байгаа бөгөөд экспортын түвшин 13%-иар өсч 7 тэрбум ам.долларын түүхэн дээд хэмжээндээ хүрсэн нь нүүрс, зэс, мах болон ноолуур, төмрийн хүдрийн экспорт 9,6,2 болон 1 нэгж хувиар тус бүр голлон нөлөөлсөн байна. Нүүрсний экспорт 36 сая тонн буюу түүхэн дээд хэмжээндээ хүрч 2.8 тэрбум ам.долларын орлого олсон байна. Импорт 36%-аар өсч 5.9 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд машин тоног төхөөрөмж, шатахуун, барилгын материал, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн орц болон хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт голчлон нөлөөлсөн байна. Гадаад худалдааны тэнцэл 39%-аар буурч 1.1 тэрбум ам.доллар болсон нь экспортын өсөлтийн удаашрал, импортын хурдацтай өсөлтэй холбоотой байна.

Тайлант онд барааны гадаад худалдааны илүүдэл 54%-аар буурсан, үйлчилгээний гадаад худалдаа алдагдал 20%-аар өссөн явдал нь гадаад төлбөрийн урсгал тэнцлийн алдагдлыг 65%-аар нэмэгдүүлж, 1.9 тэрбум ам.доллар буюу нэрлэсэн ДНБ-ны 14.6%-тай тэнцэх хэмжээнд хүргэв. Санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл 31%-аар буурч 1.8 тэрбум ам.доллар хүрсэн нь төлбөрийн тэнцэл 141 сая ам.долларын алдагдалтай гарах гол шалтгаан болсон. Жилийн эцэст гадаад валютын албан нөөц 18%-аар өсч 3.54 тэрбум ам.долларт хүрсэн байна.

2018 онд төсвийн ашиг 12 тэрбум төгрөг гарсан нь төсвийн орлого нэмэгдсэн, зардал харьцангуй тогтвортой байсантай холбоотой байна. Гэсэн хэдий ч УИХ-р батлагдсан 2019 оны төсвийн зардал түүхэн дээд хэмжээнд тогтоогдсон нь төсөв 2019 онд алдагдалтай гарах магадлалтай байна. МУ-ын Засгийн Газар 2017 оны 10 сараас бонд, үнэт цаас дотооддоо гаргасан нь дотоодын тогтмол орлогод жишиг төгрөгийн өгөөжийн муруйг үгүй хийх замаар сөргөөр нөлөөлсөн байна.

Тайлант жилийн инфляцийн түвшин улсын хэмжээнд 6.4%-аас 8.1%, Улаанбаатар хотод 7.2%-аас 9.7% болж огцом өссөн нь мах, хүнсний бүтээгдэхүүн, шатахуун, дизель түлш болон түлшний зориулалт бүхийн нүүрс мод зэрэг бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой байна. Төв Банк 2018 оны 11 сард бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөн 11% болгосон нь мөнгөний сул бодлогын мөчлөг дуусч байгааг болон инфляцийн эрсдэл өндөрсөж байгаа дохио болсон. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь 30.5%-аас 22.8% болж буурсан нь төгрөгийн ханшны огцом сулралтаас шалтгаалж байгаа бөгөөд ам.долларын эсрэг төгрөгийн ханш 9%-аар суларсан байна.


2019 онд бизнесийн болон санхүүгийн мөчлөг үргэлжлэн тэлэх хандлагатай байгаа хэдий ч макро эдийн засгийн гарч болзошгүй эрсдэлүүд байсаар байна. Үүнд: (i) Инфляцийн өндөр түвшин нь мөнгөний бодлогыг хязгаарлах, бодлогын сонголт, эдийн засгийн шинэчлэлийн боломжуудыг үгүй хийх, (ii) Макро эдийн засгийн гадаад тэнцвэрт байдал болон инфляцийн түвшинд сөрөг нөлөө үзүүлэх мөчлөгийн үеийн мөнгөний тэлэлт болон төсвийн тэлэлт, (iii) Өсөн нэмэгдэж буй урсгал дансны тэнцлийн алдагдал болон санхүүгийн дансны тэнцлийн ашиг хоорондын эх үүсвэрийн зөрөө ихсэх магадлал (iv) Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны нөхцөл муудахтай холбоотойгоор үүсэх эрсдэлүүд (v) Бизнес, хөрөнгө оруулалтын орчин, санхүүгийн системийн үйл ажиллагаа болон санхүүгийн зуучлалын нөхцөл байдал муудах.

Хөрөнгийн урсгал: Худалдааны тааламжтай нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын сэргэлтийн нөлөөгөөр мэдэгдэхүйц сайжирсан ба ДНБ-ны 15%-тай тэнцэж байна.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Инфляци: 2 жилийн дотор 7.0 нэгж хувиас 8.1% болж өссөн ба эрэлт, нийлүүлэлтийн инфляци болон валютын ханшийн нөлөөнөөс үүсэх инфляцийн эрсдэлтэй.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хос алдагдал: Төсвийн тэнцэл гадаадын шууд хөрөнгө оруулалт, цэвэр нөөцийн санхүүжилтээр алдагдалгүй гарсан боловч урсгал дансны алдагдал ДНБ-ны 15% болж өссөн



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт: Хөрөнгийн урсгалын өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн дэмжлэгтэйгээр 6.9%-д хүрсэн нь зээлийн тэлэлтийн мөчлөгийг бий болгох боломжийг бүрдүүлсэн.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Өрхийн өр: 2014 оны 4-р улирлаас хойш өрхийн дундаж цэвэр орлого хасах байгаагаар холбоотойгоор өсөлттэй гарсан.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төгрөгийн ханш: 2018 онд урсгал дансны алдагдалийн огцом өсөлт, Төв банкны үнэт цаасны богино хугацаан дах хөрвөх чадвар өндөр байсан, мөн зах зээлийн хүлээлт зэргээс үүдэн 9%-аар буурсан.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Санамж: Төлбөрийн тэнцэл зэрэг энд ашигласан гадаад секторын статистик мэдээлэл нь BPM6 гарын авлага, аргачлалаар боловсруулагдаж нэгтгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх BPM5 аргачлалаар эмхэтгэн гаргасан тоон үзүүлэлтээс ялгаатай болно.

Банкны салбар

Макро эдийн засгийн бат бөх үндэс суурьд суурилсан санхүүгийн системийн тогтвортой байдал, санхүүгийн мөчлөгийн тэлэх чиг хандлага, хөгжин дэвшиж буй зэх зээлийн нөхцөл байдал, эдийн засгийн эерэг хүлээлт, актив, пассивын түвшин тус бүр 14.9% болон 16.3%-аар нэмэгдсэн зэрэг нь банкны салбарын тасралтгүй өсөн тэлэх шалтгаан болж байна.

Системийн хувьд дотоодын зээл 3.6 тэрбум төгрөгөөр өсч (25.8%) нийт хөрөнгийн өсөлтийн 84%-г бүрдүүлж байна. Уул уурхайд суурилсан эдийн засгийн сэргэлт хэрэглээний эрэлт, хэрэгцээг нэмэгдүүлснээр зээлийн өсөлтийн 54-өөс дээш %-г хэрэглээний зээл бүрдүүлж байна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээл авах боломж хязгаарлагдмал, дутмаг байгаа үед өрхийн орлого орон сууцны зээлээс илүү хэрэглээний зээлрүү шилжих хандлагатай болсонтой холбоотойгоор 2019 оны эхэнд өрхийн удаан болон богино эдэлгээтэй бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг санхүүжүүлэх шинэ зохицуулалтыг нэвтрүүлсэн. Машин, кредит картын зээл, цалин болон тэтгэврийн зээлүүд тус бүр харгалзан 138%, 85% ба 55%-аар өссөн байна. 2018 оны зээлийн өсөлтийн 83%-г цалин болон тэтгэврийн зээл (11.5%), жижиглэнгийн болон бөөний худалдаа (4.1%), машины зээл (1.9%), барилгын салбар (1.8%), уул уурхай (1.5%) болон тээвэр болон агуулахын (1.1%) салбарын зээл эзэлж байна.

Төв банк 3-р сард бодлогын хүүг 11% -ээс 10% болгон бууруулсан ба 11 сард 11% болгож өсгөх хүртэлээ тогтвортой барьсан юм. Банкны салбарт Төв банкны үнэт цаасны үлдэгдэл болон засгийн газрын авлага 126 тэрбум ам.доллараар (2.1%) буурч 5968 тэрбум төгрөг болсон байна. Гэсэн хэдий ч засгийн газраас үнэт цаас, бонд гаргахыг зогсоох шийдвэр гаргаснаар 2017 оны 10 сараас нийт хөрөнгө оруулалтад богино хугацаатай, өгөөж багатай Төв банкны үнэт цаасны эзлэх хувь 36%-аас 75% болж огцом өсөлт үзүүлсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь хөрөнгө оруулалтын өгөөж болон зээлийн хүү буурахад нөлөөлсөнөөр Банкны хөрөнгө оруулалтын өгөөж буурахад нөлөөлсөн.

Ашигт ажиллагаагаа хангаж ажиллахын тулд банк нь хөрвөх чадвар бүхий хөрөнгөө шинэ зээлд байршуулах шаардлага гарсан боловч Төв банкны богино хугацаат үнэт цаасд байршуулсан их хэмжээний хөрвөх чадвар бүхий хөрөнгийг зах зээл шингээх боломжгүй байсан юм. Гэсэн хэдий ч зээлийн өсөлтийн хүлээн зөвшөөрөгдөх хязгаар, хурд, хамрах хүрээ банк бүрд харилцан адилгүй байна. Банкны салбарын гадаад хөрөнгийн хэмжээ нэрлэсэн дүнгээрээ 29.3%-р, ханшийн нөлөө тооцсон дүнгээрээ 18.7% -р өссөн байна.

Банкны салбарын пассив, урсгал данс болон нийт хадгаламж тус бүр харгалзан 16.3%, 37.5% болон 26.8% -аар өссөн байна. Системийн гадаад өр нэрлэсэн дүнгээрээ 10.5% -аар өссөн ч ханшийн нөлөөллийг тооцсон дүнгээрээ 1.4% -р өссөн үзүүлэлттэй байна. Өндөр төлбөрийн чадвар, дотоод эх үүсвэртэй харьцуулахад гадаад эх үүсвэрийн зардал харьцангуй өндөр байсан болон гадаад валютын ханшийн эрсдэл буурсан нь банкуудын гадаад эх үүсвэр татах сонирхлыг бууруулж байна.

Оны 2-р хагаст, тодруулбал 2018 оны 4-р улиралд 2017 онд хийгдсэн Өөрийн хөрөнгийн чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн хэд хэдэн банкууд өөрийн хөрөнгийн заавал байх доод хэмжээний шалгууртай холбоотойгоор банкны салбарын баланс болон санхүүгийн тайланд өөрчлөлт оруулсан. Үүнтэй холбогдуулан банкуудын хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэм хэмжээ болон ирээдүйн өсөлт өөр өөрөөр тодорхойлогдсон.

626 (54.5%) тэрбум төгрөгөөр өссөн чанаргүй зээлийн 1.77 их наяд төгрөг , 24 (2.9%). тэрбум төгрөгөөр өссөн хугацаа хэтрэлттэй зээл 0.84 их наяд төгрөг байснаас зээлийн эрсдэлийн санг 537 (52.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1.55 их наяд төгрөгт хүргэв. Системийн хувьд чанаргүй зээлийн харьцаа 2017 оны 12 сард 8.2% байснаас 2018 оны 11сард 12 % болж огцом өссөн боловч жилийн эцэст бага зэрэг буурч 10.1% болсон. Банкны салбарын цэвэр ашиг 2017 оны 12-р сард 249 тэрбум төгрөг байснаас буурч 2018 оны 12 сард -97 тэрбум төгрөг болж огцом муудсан нь нийт хөрөнгийн -3.0% -тай тэнцэх цэвэр алдагдалтай гарсан. 2018 онд өөрийн хөрөнгийн өгөөж хасах гарсан нь банкны салбарт сүүлийн 10 жил гарч байгаагүй үйл явдал болсон юм. 2018 онд системийн нийт хөрөнгийн өсөлт 3.5% буюу 3260 тэрбум төгрөг байсан байна.

Актив, дотоод зээл: Тус бүр харгалзан 14.9% ба 25.8%-аар өссөн. Зээлийн өсөлт 2014 оны 8 сараас хойш анх удаа хамгийн өндөр түвшинд хүрсэн.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Пассив, харилцах, хадгаламж: тус бүр харгалзан 16.3%, 37.5%, ба 26.8%-аар өссөн. Системийн гадаад өр 10.5% -аар өссөн үзүүлэлттэй.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Цэвэр ашиг: Банкны салбарын ашиг 346 тэрбум төгрөгөөр буурсан нь 96.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Энэ нь 2009 оны хямралаас хойш анх удаа тохиолдож байна.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Хөрөнгө оруулалтын багц, гадаад актив: Засгийн газрын үнэт цаасны арилжаа зогссон нь хөрөнгө оруулалтын багцад огцом өөрчлөлт оруулсан. 2018 онд 2.1% буурсан.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээл (NPL): Өөрийн хөрөнгийн үнэлгээний шалгуурын дагуу зээлийн ангилалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 626 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1774 тэрбум төг болсон.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Нийт хөрөнгө: Жилийн эхний 10 сар 342 (10.9%) тэрбум төгрөгөөр буурсан боловч 2018 оны 12 сарын байдлаар 110 (3.5%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

2018 оны санхүүгийн жил



Тайлант 2018 он, ХасБанкны хувьд хөрөнгө, эх үүсвэрийн бүтцээ илүү оновчтой болгож, активын чанар, өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шалгуур сорилт дүүрэн жил байлаа. Банк харилцагч, зээлдэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжин зээлийн хүүгээ бууруулсан нь цэвэр хүүгийн орлогыг буурахад хүргэсэн хэдий ч хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагыг оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр цэвэр ашгийн хэмжээгээ өмнөх оноос өсгөж чадсан юм. Зээл болон харилцах хадгаламжийн багцаа зорилтот түвшнээс давуулан өсгөсөн, нийт харилцагчидтайгаа хамтын ажиллагаа улам бүр бататгаж чадсан санхүүгийн жил байв.

Гүйцэтгэлийн үр дүн

ХасБанк нь 2018 онд 85.1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого үүнээс 20.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн өгөөжийг 9.6 хувьд хүргэжээ. Өмнөх оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад үйл ажиллагааны орлого 2.3 хувь, цэвэр ашиг 2.9 хувиар өссөн байна.

Үйл ажиллагааны орлого болон цэвэр ашиг өсөхөд хураамж шимтгэл зэрэг хүүгийн бус орлого голлох нөлөөг үзүүлсэн ба тайлант онд хүүгийн бус орлого 46 хувиар өссөн үр дүнтэй. Энэхүү хүүгийн бус орлогын өсөлтийг хураамж шимтгэлийн болон валютын арилжааны орлого голчлон бүрдүүлсэн байна.

Харилцагчдад олгож буй зээлийн хүүг бууруулсан, нийт эх үүсвэрийг санхүүжүүлэх хүүгийн зардал өссөн зэргээс шалтгаалан цэвэр хүүгийн орлого 2017 онтой харьцуулахад 7 хувиар буурсан.

2018 онд үйл ажиллагааны зардал 71.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 10.3 хувиар өссөн бөгөөд үүнд, дэвшилтэт технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбоотой мэдээлэл технологийн болон бизнесийн өсөлтийг дэмжих, маркетинг зар сурталчилгааны зардлын өсөлт голлох байр суурийг эзэлж байна.

Хөрөнгө ба эх үүсвэрийн үзүүлэлт

2018 онд банкны нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 2 хувиар өсөж 3.1 их наяд төгрөгт хүрсэн. Хөрөнгийн өсөлт харьцангуй байсан хэдий боловч нийт зээлийн багц 40 хувиар өсөж 1.4 их наяд төгрөгөөс 1.9 их наяд төгрөгийг давлаа.

Зээлийн багцыг бүтээгдэхүүний хувьд авч үзвэл, жижиг дунд бизнесийн, цалингийн, бизнесийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн өсөлт нийт зээлийн багц өсөхөд дийлэнхи нөлөөг үзүүлсэн. Харин сегментийн хувьд авч үзвэл, нийт зээлийн багцын өсөлтийн 66 хувийг иргэдийн банкны зээлийн өсөлт бүрдүүлж байна. Тайлант онд нийт харилцах хадгаламжийн багц өмнөх оноос 23 хувиар өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн. Нийт багцын өсөлтийн 70 хувийг хадгаламжийн өсөлт бүрдүүлж байгаа бол харилцах дансны өсөлт 30 хувийг бүрдүүлж байна.

Банк 2018 онд активын чанарын үзүүлэлтээ улам бүр бататган ажиллаж чанаргүй зээлийн багцын харьцаа үзүүлэлтийг өмнөх оноос 2.8 нэгж хувиар бууруулсан буюу чанаргүй зээлийн багц

2017 онд 110 тэрбум байснаас тайлант оны эцсийн байдлаар 98 тэрбум төгрөг болж буурсан байна.

Түүнчлэн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ тайлант онд 2.1 хувиар буурч 87 тэрбум төгрөгт хүрж буурсан нь нийт зээлийн багцын чанарын үзүүлэлт сайжирсантай салшгүй холбоотой юм. Зээлийн эрсдэл даах чадварын харьцаа үзүүлэлт 81 хувиас 86 хувь болж нэмэгдсэн нь банк зээлийн эрсдэлийг хаах хангалттай түвшний нөөц бүрдүүлсэн эрсдэлийн оновчтой бодлого хэрэгжүүлэн ажиллаж буйг илтгэж байна.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээ өмнөх оноос 22 хувиар буурсан буюу нийт 1.5 их наяд төгрөгөөс 1.2 их наяд төгрөгт хүржээ. Банк эх үүсвэрийн уян хатан удирдлагыг хэрэгжүүлж дотоодын харилцах хадгаламжийн хэмжээгээ өсгөж чадсан тул нэмэлт гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлсэнгүй.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк өөрийн хөрөнгийн хөрөнгийн удирдлагаа тухайн оны бизнес төлөвлөгөө стратегитайгаа уялдуулан, түүнд шаардагдах капиталын бүрдэл болон эрсдэлээр жигнэсэн активын өсөлтөө тодорхойлон хэрэгжүүлдэг.

Өмнөх санхүүгийн жилүүдийн нэгэн адилаар, 2018 оны туршид ХасБанк нь зохицуулагч байгууллага, Монгол банкнаас хэрэгжүүлдэг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүдийг тасралтгүй бүрэн хангаж ажилласан болно. Тайлант оны эцэст нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 9.9 хувь, нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ 15.7 хувь тус тус байгаа нь нийт зээлийн багц өссөн болон үүнтэй уялдаатай эрсдэлээр жигнэсэн активын өсөлттэй холбоотойгоор өмнөх онтой харьцуулахад буурсан байна.

Банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт нь өмнөх онтой харьцуулахад 14 нэгж хувиар буурч 30 хувьд хүрсэн ба активын уян хатан удирдлагын хүрээнд хөрвөх хөрөнгийн хэмжээгээ бууруулж зээлийн багцаа нэмэгдүүлсэн нь уг өөрчлөлтийн шалтгаан юм. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт тайлант онд буурсан хэдий ч Монгол банкнаас шаарддаг шалгуур үзүүлэлтээс даруй 500 суурь нэгжээр өндөр байгаа юм.

Эрсдэлийн удирдлага

ХасБанк нь эрсдэлийн удирдлагын сайн засаглалыг бий болгож, эрсдэлийг удирдах арга барилыг тууштай хэрэгжүүлж, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хариуцлагатай зээл олгож, улс орны эдийн засагт хувь нэмрээ оруулсаар ирсэн. Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг Банкны бизнесийн стратегитай нийцүүлснээр эрсдэлийн удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг урт хугацаанд нэмэгдүүлэхэд оршдог.

Банк нь эрсдэлийн удирдлагын соёлыг бэхжүүлж, нийт ажилчдын дунд нэгдсэн ойлголтыг бий болгох, эрсдэлийн соёлыг таниулах, түгээх зорилгоор холбогдох сургалтыг байнга зохион байгуулдаг.

Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн хүрээнд эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог бий болгож, охин компаниудад хэрэгжүүлдэг. Энэхүү тогтолцоо нь Банкны эрсдэлийн соёлоор батлагдсан бөгөөд Банкны Triple-P ёс зүйгээр батлагдсан юм.



2018 онд Эрсдэлийн удирдлага нь дараах ололтуудад түлхүү анхаарч ажилласан:

- Machine learning - Банк нь Machine Learning-д хийх хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлж, эрсдэлийг тодорхойлох, хэмжих, тайлагнах зориулалттай Machine Learning дээр суурилсан загвар, арга барилыг ашигласан;
- Автоматжуулалт - Банк нь зардлын хувьд үр ашигтай шийдвэр гаргах, эрсдэлийг хэмжих, удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг; Эрсдэлийн удирдлага нь хэд хэдэн шийдвэр гаргах үйл явцыг хялбаршуулах, автоматжуулах олон төрлийн амжилттай санаачилга гаргасан; ба
- Интеграцлал, шинэ загвар, сургамж, үйл ажиллагааны эрсдэлд суурилсан үйл ажиллагааны процесс нь үр ашиг муутай үйл ажиллагааг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

Эрсдэлийн удирдлагын арга барил

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан бөгөөд эрсдэлийг хариуцах, хяналт тавих чиг үүргийг дараах байдлаар тодорхойлдог.

- Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийг хариуцах эзэн байх бөгөөд эрсдэлийг үнэлэх, хянах, бууруулах чиг үүрэгтэй.
- Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийг хянах чиг үүрэгтэй бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг тогтоох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй. Ингэснээрээ Хамгаалалтын хоёрдугаар бүс нь Хамгаалалтын нэгдүгээр бүсийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох зааварчилгаагаар хангаж ажилладаг.

- Хамгаалалтын гуравдугаар бүс нь Дотоод аудитын нэгж байх бөгөөд тэдгээр нь Хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хараат бус үнэлэлт өгөх чиг үүрэгтэй.

Банкны эрсдэлийн удирдлагын гол чиг үүрэг нь Банкны эрсдэлийн удирдлагын болон хяналтын тогтолцоог зохистой удирдах, боловсронгуй болгох, Хамгаалалтын гурван бүсийн чиг үүргийг улам сайжруулахын зэрэгцээ Банкны бизнесийг дэмжих юм.

Стресс тест нь Банкны эрсдэлийн удирдлагын чухал хэсэг бөгөөд стресс тестийн шинжилгээнд макро эдийн засаг, геополитик, үйл ажиллагаа болон Банк, Монгол Улсад хамаарах бусад болзошгүй эрсдэлүүдийг хамруулдаг. Банкны хувьд нэн чухал болон бусад учирч болзошгүй эрсдэлээс хамаарч сценарийг тодорхойлох ба энэ нь Банкны эрсдэлийг урьдчилан бууруулах ач холбогдолтой. Стресс тестийн шинжилгээ нь Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлага Банканд учирч болзошгүй эрсдэлийн шинж чанар, цар хүрээг илүү сайн тодорхойлон холбогдох шийдвэр гаргахад туслалцаа үзүүлэх аргачлалын нэг байдаг.

Эрсдэлийн удирдлагын засаглал

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоох, эрсдэлийг үр дүнтэйгээр удирдах эцсийн хариуцлагыг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл хүлээдэг. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрхийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийг хянаж, эрсдэл нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж хүргүүлэх чиг үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны чиг үүргийн нэг хэсэгт Банкны эрсдэлийн удирдлагын арга барил, эрсдэлийн хяналт нь зохистой түвшинд, үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавихаас гадна томоохон дүнтэй зээлийн саналыг шийдвэрлэх асуудлууд багтдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын бичиг баримтыг баталж, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн цар хүрээ, зээлийн багц, стресс тест, сценарионуудын дүн шинжилгээ зэргийг тусгасан эрсдэлийн удирдлагын тайлан болон Банкны бизнесийн төлөвлөгөө болон зах зээлийн эрсдэлийн дүн шинжилгээний тайланг мөн хэлэлцдэг.

Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрсдэлийн удирдлагыг Банкны Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Эрсдэл хариуцсан захирал хэрэгжүүлдэг. Банкны хороодын бүтэц, засаглалын дагуу эрсдэлийн удирдлагын бодлого, журмыг батлах, эрсдэлийг удирдах эрх мэдлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх холбогдох хороодод шилжүүлсэн.

Хянан нийцүүлэлт ба Санхүүгийн гэмт хэрэг

Сүүлийн 2 жилийн хугацаанд Банкны Хянан нийцүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, Тэнгэр Санхүүгийн Нэгдэлээс дэмжлэг хүлээн ажиллаж ирсний үр дүнд Тэнгэр Санхүүгийн нэгдэл болон Банк нь дэлхий стандарт шаардлагатай хөл нийлүүлэн алхаж байна.

Банкнаас Санхүүгийн гэмт хэргийн эрсдэл болон Хянан нийцүүлэлтийн удирдлагын чадавхийг дээшлүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах чадварыг эрс нэмэгдүүлж байна.

Эрсдэлийн удирдлага

Монголын эдийн засаг болон банкны өөрчлөгдөж буй олон бэрхшээл, шаардлагуудыг даван туулахуйц хянан нийцүүлэлтийн тогтолцоог амжилттай бий болгож, дэлхийн хэмжээний зохицуулагч болон хууль сахиулах байгууллагуудтай санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хамтын ажиллагааг бий болголоо. 2018 онд банк нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг болон хориг арга хэмжээний бодлогын хүрээнд хянан нийцүүлэлтийн үндсэн технологийг амжилттай нэвтрүүлж дууслаа. Түүнчлэн банкны санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд ямарваа нэгэн алдаа дутагдал гарах эсэхийг үнэллээ.

Эрсдэлийг илрүүлэх, тайлагнах хяналтын процессыг илүү чанаржуулах хялбаршуулахад хиймэл оюун ухааны арга хэрэгслийг ашиглаж байна. Ингэснээр өндөр эрсдэл бүхий бүтээгдэхүүн үйлчилгээ болон харилцагч дээр илүү төвлөрөн банкны санхүүгийн гэмт хэрэг болон хянан нийцүүлэлтийн удирдлагын үр дүн болон үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна.

2018 оны турш банк нь Харилцагчийг хамгаалах 7 зарчим болон шалгуур үзүүлэлтүүдийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд Ухаалаг хөдөлгөөний гэрчилгээг дахин авлаа. Энэ сэдвийн хүрээнд Банкны Хянан нийцүүлэлтийн албан үүргийн хувьд зохицуулагч, хянагч болон бусад салбарын байгууллагуудтай хамтран ажиллаж харилцагчийг хамгаалах, хянан нийцүүлэлтийн зарчмуудын талаар илүү сайн мэдлэгийг олж авсан.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банк нь зээлийн бодлого, журмыг боловсруулан, зээлийн эрсдэлийг удирдах зохих орчин, нарийвчлан тодорхойлсон процесс, зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагатай хяналтыг бий болгож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж зээлийн эрсдэлийг удирддаг.

2018 онд хадгалагдаж буй зээлийн дансны өсөлт нь татан буугдсан багцын төсөвлөсөн бууралтаас нөхөгдөөгүй тул 2018 онд банкны үнэ цэнийн буурсан нийт хөрөнгө буурсан байна. Банк зээлийн чанар сайжирч, чанаргүй зээлийн харьцаа 4.6%, өмнөх оныхоос 230 суурь нэгж сайжирсан байна. Чанарын чанаргүй зээлийн багц буурснаас эрсдэлийн хамрах хүрээ 87.6% аюулгүй түвшинд байна.

Эрсдэлийн удирдлага нь Банкны зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих чадвархийг дээшлүүлэх чиглэлээр олон арга хэмжээг авдаг. Үүнд зээлийн боловсронгуй оноо, цуглуулгын загвар, Machine Learning дээр суурилсан эрт сэрэмжлүүлгийн дохиол зэрэг багтсан болно. Цаашилбал, Эрсдэлийн удирдлага Монгол Улсын хууль тогтоомжийн боловсруулалтаас өмнө олон улсын жишигт суурилсан Базел II анализын ашиглалтыг эрчимжүүлэхээр зорьсон. Банк нь 2017 онд Активын чанарын үнэлгээ хийсний дараа барьцааны үнэлгээний дотоод үнэлгээний стандартыг олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, сайжруулсан. Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага 2018 онд Банк нь зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийг Банкны хүлээн зөвшөөрөх хэмжээний түвшинд удирдлаа.

Гадаад зах зээл дэх ам.долларын ханш чангарсан, худалдааны нөхцөл байдал муудсантай холбоотойгоор 2018 онд төгрөгийн ханш долларын эсрэг 8.9 хувиар суларсан. Банк гадаад валютын позицийг валютын зах зээлийн хөдөлгөөнтэй уялдуулан хянаж, өдрийн гадаад валютын нээлттэй позицийн бодит ашиг, алдагдлыг Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk)-ийн хүрээнд тогтвортой удирдлаа.

Банкны өндөр хадгаламжийн нөөцийн ачаар 2018 онд банкны хөрвөх чадварын үзүүлэлт тогтвортой хэвээр байна. Иргэдийн хадгаламжийн өсөлт жилийн турш 22.7%-иар өсч, Банкны зээлийн тэлэлтийг дэмжиж өгсөн. Өсөлт нь хадгаламжийн хүү буурч байгаа үед тогтвортой хадгаламжийн өсөлтөөс үүдэлтэй байв.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

ХасБанк Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хорооны хяналт дор үйл ажиллагааны эрсдэлийг удирдах арга барилаа шинэчлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн төдийгүй эрсдэлийн тохиолдол бүрийг мэдээлэх арга барилаас хяналтын зохистой бодлого тогтоох арга барилд шилжиж байна. Мөн түүнчлэн, Банк нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл дэх бусад охин компаниудад ижил төстэй стандарт, зорилтыг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж хамтран ажилласан. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх, илрүүлэх, саармагжуулахад чиглэсэн үр нөлөөтэй, шуурхай хяналтын тогтолцоог тодорхойлж, хэрэгжүүлэх талаар тухайн процессийн эзэн удирдан чиглүүлж байна. Процессыг нягтлан хянах, хяналтын дүн шинжилгээ хийх нь үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг тодорхойлж, тэр нь үйл ажиллагааны эрсдэлийн хүлээн зөвшөөрөхүйц түвшний чиг баримжаа болдог. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага дор хяналт шалгалтын ажлыг нягтлан үнэлж, шалгаж байх нь онцгой чухал ач холбогдолтой бөгөөд дээр нь эрсдэлийн тохиолдол бүрийг тайлагнаж, дүн шинжилгээ хийж байх нь зүйтэй.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогын тухай ойлголтыг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд ажилтнуудыг дотоод болон зайны сургалтад хамруулж байгаа бөгөөд цаашид ч хамруулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Залилангийн ба Санхүүгийн гэмт хэрэг

2018 оны турш, Банк бүх төрлийн сэжигтэй үйл ажиллагааг газар дээр нь болон зайнаас шалгах үр дүнтэй арга барил чадвар, чадамжаа сайжруулсан.

Дотоод аудиторуудын хяналт дор ажилладаг Залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба нь банканд батлагдсан аудитын арга техникийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь хянах үйл явцын хугацааг мэдэгдэхүйц багасгахад тусаллаа. Залилангийн тохиолдлыг эрт илрүүлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор системд 6 автомат хяналтын хэрэгслийг идэвхжүүлэн ажиллаж байна.

2018 онд, Залилантай тэмцэх албаны хамт олон дотоод хяналтын тогтолцооны зөрүүгээс болж Банкнийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийллээ. Залилангийн аливаа төрлийн үйл ажиллагаа, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бүх ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба үргэлжлүүлэн ажиллаж байна.

Хууль эрх зүйн эрсдэл

Хуулийн хэлтэс нь 2018 оны зун Үйл ажиллагаа хариуцсан захирлын удирдлагаас Эрсдэл хариуцсан захирлын удирдлагад шилжсэн. Хуулийн хэлтэс нь эрх зүйн орчныг бэхжүүлэх, хууль зүйн эрсдэлийг удирдах, шүүх болон бусад үйл ажиллагаанд банкнийг төлөөлөн оролцох, хууль зүйн асуудлаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг. Эрсдэл хариуцсан захирлын удирдлагад шилжсний дараа Бизнесийн нэгжүүдтэй ажиллах, бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллах чиглэлээр нэгжүүд хоорондоо харилцан ойлголцож чадсан нь үр дүнд хүрэв.



2018 онд зээлийн үйл ажиллагааны хууль зүйн эрсдэлийг удирдах ажлын хүрээнд Банкны хэмжээнд бүтээгдэхүүний стандарт гэрээний загварыг боловсронгуй болгох, шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Хуулийн хэлтэс нь зохицуулагч байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан шинэ шаардлагуудыг хангаж ажиллахад хувь нэмэр оруулж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Кибер болон мэдээллийн технологийн эрсдэл

Банк нь Банкны кибер хяналтын бодлогыг бэхжүүлж, аюул заналыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, хандалтыг хянах, төлбөрийн системийг хянах, өгөгдлийг хамгаалах, нөөцлөх, нөхөн сэргээх зэрэг Банкны тогтвортой байдал, кибер аюулгүй байдлын чадавхийг сайжруулах санаачилгыг хэрэгжүүлсээр байна. Харилцагчдын мэдээллийн нууцлалыг сайжруулах, бизнесийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор Банк вирус, хорт вирус болон бусад төрлийн халдлагаас урьдчилан сэргийлэх системийн дэвшилтэт системийн нөөц бололцоог сайжруулав. Түүнчлэн, уг асуудалд туслах зорилгоор үүлэн аюулгүй байдлын хэрэгжилтийг эхлүүлсэн.

Банк нь шинэчлэгдсэн SWIFT аюулгүй байдлын стандарт, PCI DSS олон улсын төлбөрийн картын стандартын шаардлагын дагуу бүх шаардлагыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн аудитыг хийж гүйцэтгэсэн.

Интернэт банк болон бусад дижитал банкны системийн системийн хамгаалалтын түвшинг холбогдох стандартын дагуу сайжруулав.

Монголын Банкны Холбоогоор дамжуулан Банкны Кибер Эрсдэлийн баг нь Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэх, аюул занал, эсрэг арга хэмжээ авах талаар салбарын харилцаа холбоог хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Мэдээллийн технологи



ХАСБАНКНЫ ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гол ололтууд:

- Олон улсын төлбөрийн картын аюулгүй байдлын PCI/DSS стандартын дагуу 3G сүлжээгээр дамжиж байгаа ПОС-н гүйлгээнд 2 давхар шифрлэлт хийж, мэдээллийн нууцлалыг улам сайжруулав.
- Банк хоорондын 3 сая төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээг 3 секундэд хийдэг болов.
- Төв алба болон салбарын 1500 гаруй компьютеруудын аюулгүй байдал, програм хангамжийг төвлөрсөн удирдлагаар хянах, удирдах системийг нэвтрүүлж, ашиглалтад оруулав. Мөн нийт 650 гаруй компьютерийг орчин үеийн өндөр хурдтай компьютерээр шинэчлэн, ажилтны бүтээмжийг нэмэгдүүлэх ажил хийгдлээ.
- Бид 2018 оны 4 сард найдвартай тасралтгүй ажиллагааны дэвшилтэт орчин үеийн технологийг нэвтрүүлэн, интернэтийн сүлжээний тасалдлаас хамаарч үүсдэг байсан доголдлыг 0% болгон үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүллээ.
- 2018 оны 11 сарын 10-нд ХасБанк үндсэн болон нөөц дата төвүүддээ орчин үеийн дэвшилтэт технологи Oracle ExaData сервер машинуудыг амжилттай суурилуулан нэвтрүүллээ. Энэ төсөлд нийт дотоод гадаадын нийлүүлэгч компанийн 15, төв албаны 40, салбар тооцооны төвүүдийн 500 гаруй ажилтнууд хүчин чармайлт гарган ажилласан. Төслийн үр дүнд харилцагчийн гүйлгээ болон өдөр өндөрлөгөөний процесс 2-3 дахин хурдаслаа.
- Нөөц дата төвийг Дархан хот дахь Мобиком компанийн дата төв рүү шилжүүлснээр олон улсын стандарт болон МонголБанкнаас арилжааны банкуудад тавигддаг шаардлагыг бүрэн хангав.

Ингэснээр ХасБанкны нөөц дата төв болон гүйлгээний системүүдийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагаа илүү сайжирлаа.

ЦАХИМ БАНК

- Бид харилцагч байгууллагуудын системд зориулсан API сервисүүдийг бий болгосон ба ингэснээр харилцагч байгууллагууд өөрсдийн систем дээрээс банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдаа хүргэх боломжтой боллоо. Тухайлбал, ERP систем дээрээсээ ажилтнуудынхаа цалингийн гүйлгээг хийх боломжтой боллоо.
- Харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд тулгуурлан НӨАТ-ын буцаалтыг зээл хэлбэрээр авах үйлчилгээг 1.5 сарын хугацаанд нэвтрүүллээ. Энэхүү үйлчилгээг Татварын Ерөнхий Газар, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГазар, СофтПос ХХК-тай хамтран хэрэгжүүллээ.
- Харилцагч мобайл банкны – USSD үйлчилгээгээр дамжуулан хадгаламж барьцаалсан зээлийг онлайнгаар буюу 8 секунд дотор зээл авдаг болсон.
- Төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” системтэй холболт хийж, харилцагчаас 9 төрлийн лавлагааг шаардахгүйгээр хурууны хээгээр баталгаажуулан авч, харилцагчийн салбар дээр ирэх давтамжийг бууруулан, зээл олгох процессын хурдыг нэмэгдүүлсэн. Мөн төслийн хүрээнд харилцагчийн хадгаламжийн болон дагалдах үйлчилгээний хувийн хэргийг цахимжуулах бичиг баримтын нэгдсэн (DMS) системийг нэвтрүүлэв.
- Татварын Ерөнхий Газар, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГазарт хэрэгжиж байгаа “Татварын Удирдлагын Нэгдсэн систем”-тэй холболт хийж, улсын хэмжээнд нийт харилцагчдаа салбар болон интернэт банкны үйлчилгээгээр дамжуулан татвар төлөх боломжийг бий болгов.
- Банкинд анх удаа аналитик тайлангийн олон улсын шилдэг системүүдийн нэг болох QlikView системийг нэвтрүүлэв. Ингэснээр бизнес хэрэглэгч нь тайланг дурын байдлаар, хялбар, хурдан хугацаанд үүсгэх боломжтой болсон.
- Харилцагч байгууллагуудтай хамтран бэлэглэлийн GIFT CARD гаргах боломжийг нэвтрүүлсэн. Эхний ээлжинд И-Март сүлжээ дэлгүүртэй хамтран бэлэглэлийн картыг зах зээлд гаргасан.
- Мобикомтой хамтарсан co-brand картыг зах зээлд гаргав. Ингэснээр харилцагч ХасБанкны картаараа хийсэн худалдан авалт тутамдаа Candy оноо цуглуулах боломжтой болсон.

Дотоод аудит



Дотоод аудит нь группийн дотоод хяналтын тогтолцооны хамгаалалтын гуравдугаар бүс бөгөөд хараат бус, бие даасан үйл ажиллагааг явуулахдаа олон улсын шилдэг туршлага, мэргэжлийн стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аргачлалыг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд а банкны бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэлсний үндсэн дээр аудитын төлөвлөгөө боловсруулан гаргадаг.

Дотоод аудитын газар нь аудитын арга аргачлалыг тогтмол сайжруулан, шинэчилж олон улсын шилдэг туршлагатай хөл нийлүүлэн ажиллахыг зорилго болгодог. Энэ жил бид дата шинжилгээг аудитын үйл ажиллагаанд түлхүү хэрэгжүүлэхээр анхааран ажиллаж технологид суурилсан тасралтгүй хяналт болон зайны аудитыг хэрэгжүүлэх болсон. Ингэснээр аудитын нөөцийг зохистой удирдах, болзошгүй эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэн сэргийлэх болон алдаа зөрчлийг залруулах боломжтой болсон. Дотоод аудит нь тусгайлсан аудитын хэрэгслүүд ашиглан нийцлийн болон ашиглангийн шинжтэй үйлдлийг илрүүлэн ажиллаж байна. Мөн энэ онд бид хамгаалалтын нэг дүгээр бүсийн хяналтыг улам сайжруулах үүднээс автоматчилагдсан хэрэгслүүдийг боловсруулан ашиглаж, алдаа илрүүлэх болон мэдээллийн чанартай тайлангуудыг нийт салбаруудад сарын давтамжтай хүргүүлж эхэлсэн.

2018 онд бид Улаанбаатар хотын 3 HUB салбар буюу нийт 24 хотын 24 салбар тооцооны төв, орон нутгийн 13 салбар тооцооны 13 төв болон зайнаас 2 салбарт аудит хийв. Учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэхийн тулд энэ жил анх удаа сэдэвчилсэн аудитыг

хийж эхэлсэн нь ба дата засаглал, орлогын алдагдлын аудитууд хийсэн. Эрсдэлд суурилсан төлөвлөгөөний хүрээнд 2 процессын аудитыг хийсэн. Түүнчлэн мэдээллийн технологийн аудитын хүрээнд эрсдэлийн үнэлгээнд суурилан цахим аюулгүй байдлын төв, дата засаглал, мэдээллийн технологийн төслүүдийг гүйцэтгэсэн. МТ-ийн аудитын төлөвлөгөө болон дотоод нөөцийг байгууллагын стратеги, зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Дотоод Аудитын уламжлалт арга барилыг орчин үеийн шинэлэг аргачлалаар баяжуулахын зэрэгцээ аудитын мөрөөр өгөх зөвлөмжийн агуулгыг банкны үйл ажиллагаанд үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарлаа түлхүү хандуулж байна. Эдгээр зөвлөмжүүд нь банкны стратеги зорилгод хүрэхэд чухал хувь нэмэр бүхий засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой тогтолцоог дэмжихэд чиглэдэг. Аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг сар бүр хянаж байна.

Тэргүүлэх туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дотоод Аудит нь өөрсдийн үйл ажиллагааг Дотоод Аудиторуудын Олон Улсын Институт (IIA)-ээс боловсруулсан чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөр (QAIP)-тэй нийцүүлэн 4 дэх жилдээ үнэлж байна. Аудитын чанарын үнэлгээг аудит тус бүрээр үнэлдэг ба дотоод аудитын өөрийн үнэлгээг жилд нэг удаа үнэлж хэвшээд байна.

Түүнчлэн бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшин боловсон хүчин бэлдэх зорилготой ажилладаг ба энэ ажлын хүрээнд CIA болон CISA зэрэгтэй аудиторуудтай болсон. Мөн бид аудиторуудаа дотоодын болон олон улсын сургалт, семинарт тогтмол хамруулж аудиторуудын чадвар, чадамжийг бэхжүүлж байна.

Компанийн засаглал



ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛ

Компанийн засаглалын хүрээ

Зохистой засаглал нь ХасБанкны байгууллагын соёл, үнэт зүйлсийн салшгүй хэсэг бөгөөд банкны бизнесийг тогтвортой байдлаар амжилттай хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой бусад талуудад урт хугацааны үнэ цэнэ бий болгох, ХасБанканд итгэх итгэлийг бэхжүүлэх үндэс суурь болж ирсэн. Бид Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, гадаад болон дотоод, том болон жижиг зэрэг бүх хувьцаа эзэмшигчид тэгш эрхтэй байх, бүх шатандаа тайлагнах, мэдээлэл өгөх, ил тод байдлыг хангах, нэгдмэл сонирхолтой бүх талуудын өмнө хариуцлага хүлээх, шийдвэр гаргалтад хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримтлах, олон улсын жишигт нийцсэн засаглалын хэм хэмжээг хэрэгжүүлэх дээр суурилсан зохистой сайн засаглалыг хөгжүүлж ажиллахыг эрмэлздэг.

ХасБанк нь Монгол Улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан арилжааны банк бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкны салбарын зохицуулагч Монголбанк (Төв Банк)-аас гаргадаг засаглалын дүрэм, журмын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Бид “Банкны зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохистой засаглалын тайлан гаргаж, Монголбанканд хүргүүлж тайлагнадаг.

2018 онд ХасБанкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь зохистой засаглалын зарчмуудын дагуу ажиллаж, Компанийн засаглал, хянан нийцүүлэлтийн тогтолцоог цаашид сайжруулах дээр анхаарч ажилласан.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Банкны дотоод журмын дагуу толгой компани ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкныг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсөв, мөн Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашиг гэсэн эрхэм зорилгын хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулдаг, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулж болдог.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкныг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй. Зохистой засаглалын тогтолцооны хүрээнд ТУЗ-д шууд тайлагнадаг дотоод аудитор болон компанийн нарийн бичгийн даргыг удирдлагын түвшний албан тушаалд ажиллуулдаг.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2018 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар Банкны 2017 оны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2017 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, сонгох, ТУЗ-ийн 2018 оны төсөв, 2017 оны ногдол ашиг хуваарилах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцож, хувьцаа эзэмшигчдийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтыг дэмжиж ажилласан.

Компанийн засаглал

ТУЗ-ийн бүтэц

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох нэг гишүүн, 2 хараат бус гишүүнээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй байсан. ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, аливаа хувьцаа эзэмшигчийн холбогдох, нэгдмэл сонирхолтой этгээд бус, хараат бус байр суурьтай хувь хүн гүйцэтгэдэг. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банкны салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

#	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Чулууны Ганболд	ТУЗ-ийн дарга	Цөөнх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл
2	Магваны Болдоо	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	-*
3	Нямтайширийн Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	Монголын Алт (МАК) Корпораци
4	Санжай Гүпта	ТУЗ-ийн гишүүн	ОУСК
5	Жулиан Хили	ТУЗ-ийн гишүүн	ЕСБХБ
6	Риожи Нишимура	ТУЗ-ийн гишүүн	ОРИКС Корпораци
7	Ив Жако	ТУЗ-ийн гишүүн	Канадын Үндэсний Банк
8	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	Ронок Партнерз
9	Баянсаны Уламбаяр	Хараат бус гишүүн	Хараат бус
10	Нираж Вэдва*	Хараат бус гишүүн	Хараат бус

*Дүрэмд заасны дагуу
*ТУЗ-ийн шийдвэрээр 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилогдсон гишүүд

ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг

ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба энэ талаар Банкны дүрэмд тодорхой заагдсан байдаг. ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын хооронд үр дүнтэй ажлын харилцаа, эрх мэдлийн тэнцвэртэй байдал, тайлагналт, шийдвэр гаргалтад бие даасан байдал байдаг.

ХасБанкны ТУЗ-ийн даргаар 2004 оноос хойш Чулууны Ганболд ажиллаж байгаа. Ч.Ганболд нь ХасБанкны Толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн цөөнх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшиж ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон. ХасБанкны Гүйцэтгэх захирлаар 2014 оноос хойш Магваны Болдоо ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үнэлэх ажлыг удирдах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж боловсруулах, хурлаар асуудал бүрийг зохистой түвшинд хэлэлцэж, гишүүн тус бүрээс хэлэлцүүлэгт оролцож санал гаргах явдлыг дэмжин ажилладаг. ТУЗ-ийн дарга шийдвэр гаргах явцад ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн багийн ажиллагааг хангаж ажилладаг. Үүнээс гадна ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлыг чиглүүлж, удирдлага зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилладаг.

Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, ТУЗ-өөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг хариуцдаг.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа өгнө эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. ТУЗ-д орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, сонгох, улируулан сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журам болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журамд тусгагдсан байдаг. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн Яамны хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөх үүднээс 2017 онд Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, хараат бус гишүүний талаарх тусдаа заалт оруулсан.

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшлүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, ТУЗ-д зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

Хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай Банканд мэдэгддэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн хурлаар сонгодог.

ТУЗ-ийн дараах гишүүдийг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох эсхүл улируулан сонгохоор оруулж батлуулна.

- Майкл Мадден (улируулан сонгох)
- Нямтайширийн Цэлмүүн (улируулан сонгох)
- Санжай Гүпта (улируулан сонгох)
- Нираж Вэдва (сонгох)

ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг.

2018 онд ТУЗ-ийн 4 ээлжит, 1 ээлжит бус хурлыг Улаанбаатар хотод хуралдуулсан. Хурлын ирцийг дараах хүснэгтээр харуулав.

#	Огноо	Хурал	Ирц
1	2018 оны 3-р сарын 28	ээлжит	10/11
2	2018 оны 3-р сарын 29	ээлжит бус	10/11
3	2018 оны 6-р сарын 13	ээлжит	9/10
4	2018 оны 9-р сарын 13	ээлжит	10/10
5	2019 оны 12-р сарын 05	ээлжит	10/10

2018 онд ТУЗ нь 40 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 8 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр эчнээ санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна ТУЗ-ийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

ТУЗ-ийн гишүүдийн цалин

ТУЗ-ийн гишүүд ТУЗ, хорооны хуралд оролцох болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг. ТУЗ-ийн гишүүний цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог. Зохистой засаглалын зарчмын¹ дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй тогтоодог.

ТУЗ-ийн гишүүнд хуралд оролцсонтой холбоотой зардлын нөхөн олговор олгодог. Нөхөн олговор олгох журмыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан байдаг. ТУЗ-ийн гишүүн зөвлөх үйлчилгээний хөлс болон өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт

Зохистой засаглалын зарчим, Компанийн хуулийн 75.8 дугаар заалтын дагуу ТУЗ-ийн гишүүд зохистой засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авах үүрэгтэй. 2018 онд ТУЗ-ийн 2 гишүүн Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан Компанийн ТУЗ-ийн гишүүн, н/б дарга нарт зориулсан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

ТУЗ-ийн хороод

ХасБанкны ТУЗ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зориулалттай. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог ба 2018 онд байнгын хороодын ээлжит хурлыг 4 удаа улирал бүр хуралдуулсан.

¹Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”

Компанийн засаглал

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд: (i) ТУЗ гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох, (ii) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах, эдгээр болно. Хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтоолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материалыг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй.

Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналтын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, өрдийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай.

Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД²

Санжай Гүпта, дарга
Чулууны Ганболд
Риожи Нишимура
Жулиан Хили
Нямтайширийн Цэлмүүн
Ив Жако
Баянсаны Уламбаяр

ГИШҮҮД³

Риожи Нишимура, дарга
Жулиан Хили
Санжай Гүпта
Баянсаны Уламбаяр (*хараат бус гишүүн*)
Нираж Вэдва (*хараат бус гишүүн*)

ГИШҮҮД⁴

Баянсаны Уламбаяр (*хараат бус гишүүн*), дарга
Майкл Мадден
Нямтайширийн Цэлмүүн
Ив Жако
Нираж Вэдва (*хараат бус гишүүн*)

СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА

2018 онд ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд толилуулгын хуудсыг бөглөж, сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж мэдээлсэн. ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчлийг мэдэгдэж мэдээлэх үүрэгтэй.

ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүн тус бүрийн үнэлгээ хийдэг. Банкны ТУЗ нь 2018 онд өөрийн үйл ажиллагааны болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээг хийсэн болно.

АУДИТ БА ТАЙЛАГНАЛТ

ТУЗ нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-д мэдээлэл тайлбар өгөх, ТУЗ-ийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2014 онд Эрнст Янг компанийн оронд хөндлөнгийн аудитороор томилогдсон Делойт компани нь 2018 оны аудит хийхээр дахин томилогдсон.

²2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

³2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

⁴2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

Шагнал



ТОП-100 аж ахуйн нэгж – МУ-ын Засгийн газар, МҮХАҮТ

“Банкны салбарын шилдэг Энтрепренер” - МҮХАҮТ



Монгол Улсын Шилдэг банк - Global Finance сэтгүүл

Зүүн Ази болон Номхон Далайн орнууд дахь “Хурдацтай өсч буй банк” - Олон Улсын Санхүүгийн Корпораци /IFC/

“Жижиг дунд бизнесийг дэмжигч Монгол Улсын шилдэг банк” – Asiamoney awards, Euromoney сэтгүүл

Корреспондент
банкууд

	Канадын Үндэсний Банк Монреаль, Канад	BNDCCAMMINT
	Австрали ба Шинэ Зеландын Банк Групп Мельбурн, Австрали	ANZBAU3M
	БНХАУ-ын Хөдөө аж ахуйн Банк Өвөр Монгол дахь салбар, БНХАУ	ABOCCNB050
	БНХАУ-ын Аж үйлдвэр ба Худалдааны Банк Өвөр Монгол дахь салбар, БНХАУ	ICBKCNCBJNMA
	Хятадын Үндэсний Банк Хонконг дахь салбар, Хонконг	BKCHHKHH
	АйНЖи Бельги Брюссель, Бельги	BBRUBEBB010
	БаоШанг Банк Өвөр Монгол, БНХАУ	BTCBCNBJ
	ХайпоВэрэйнс Банк Мюнхен, Герман	HYVEDEMM
	ӨүСиБиСи, Сингапур ӨүСиБиСи Өмнөд Төв , Сингапур	OCBCSGSG
	Сбер Банк Москва, ОХУ	SABRRUMM
	ТрансКапитал Банк Москва, ОХУ	TJSCRUMM
	Токио Банк Мицүбиши, юэФЖи Токио, Япон	BOTKJPJT
	Сүмитомо Мицүи Банк Корпораци Токио, Япон	SMBCJPJT
	Күүкмин Банк Сөүл, Солонгос	CZNBKRSE
	КэйИБи Хана Банк Сөүл, Солонгос	KOEXKRSE



Хаяг

Олон Улсын Худалдааны төв
Жамъян гүний гудамж - 9
Ш/салбар 20А, ш/х-72
Улаанбаатар-14200, Монгол улс

Утас: +976 (11) 75771888
Факс: +976 (11) 328701
И-мэйл: info@xacbank.mn
SWIFT: [cacbmnuu](#)
www.xacbank.mn